



МОНГОЛБАНКНЫ ЭДЭЭЛЭЛ



Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт - төгрөгийн тогтвортой байдлыг хангахад оршино.

2022 • № 61

ЗАЙНААС УНШУУЛ

Б.Лхагвасүрэн: ХҮЛЭЭЛТ
ЭВДЭГДЭХЭЭС
СЭРГИЙЛЖ
БОДЛОГЫН
ШИЙДЭМГИЙ АРГА
ХЭМЖЭЭГ АВЧ БАЙНА

КОРРЕСПОНДЕНТ
БАНКНЫ
ХАРИЛЦААНЫ
ӨНӨӨГИЙН БАЙДАЛ



ЗӨВХӨН АЛБАН ХЭРЭГЦЭЭНД



МӨНГӨНИЙ БОДЛОГЫН МЭДЭГДЭЛ

БОДЛОГЫН ХҮҮГ НЭМЭГДҮҮЛЭХ ТУХАЙ

Дугаар: 2022/03

Огноо: 2022 оны 6 дугаар сарын 22-ны өдөр

Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2022 оны 6 дугаар сарын 20, 22-ны өдрийн ээлжит хурлаар эдийн засаг, банк, санхүүгийн зах зээлийн өнөөгийн байдал, гадаад, дотоод орчны төлөв, эрсдэлийг харгалзан бодлогын хүүг 1 нэгж хувиар нэмэгдүүлж, 10 хувьд хүргэх шийдвэрийг гаргалаа.

Жилийн инфляц 2022 оны 5 дугаар сард улсын хэмжээнд 15.1 хувь, Улаанбаатар хотын хэмжээнд 16.2 хувьтай гарав. Шатахуун, хүнс болон импортын барааны үнийн өсөлт инфляцын дийлэнх хэсгийг бүрдүүлж байна. Тодруулбал, дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнэ өссөнөөс дотоодын шатахууны үнэ нэмэгдсэн бол тээвэр, логистикийн саатал, нийлүүлэлтийн доголдол үргэлжилж, үйлдвэрлэлийн орц болон тээврийн зардал нэмэгдсэн нь хүнсний үнэ сүүлийн 2 сард хурдтай өсөхөд нөлөөллөө. Гадаад инфляц, ханшийн нөлөөгөөр импортын бараа, бүтээгдэхүүний үнэ өссөн нь бусад дотоодын бараа, бүтээгдэхүүний үнийг өсгөж байна. Эдгээр хүчин зүйлсийн нөлөө ирэх улирлуудад хадгалагдахаар байгаа тул инфляц Төв банкны зорилтот интервалын орчимд тогтворжих хугацаа хойшиллоо.

Хилийн хязгаарлалттай холбоотойгоор нүүрс, газрын тосны экспорт саарч, уул уурхайн салбарын өсөлт хүлээлтэд хүрээгүй ч худалдаа, үйлчилгээ, бүтээгдэхүүний цэвэр татвар зэрэг уул уурхайн бус салбарын үйлдвэрлэл сайжирч, эдийн засгийн өсөлтийг дэмжлээ. Сүүлийн 5 улирал дараалан агшаад байсан өрхийн хэрэглээ энэ оны 1 дүгээр улиралд сэргэж, дотоод эрэлт нэмэгдэв. Гадаад эрэлтийн төлөв, хилийн хязгаарлалтын асуудлаас шалтгаалан уул уурхайн салбарын өсөлт энэ онд удаашрахаар байгаа бол цар тахлын хязгаарлалтууд суларч, дотоод эрэлт сайжирснаар уул уурхайн бус салбарын сэргэлт үргэлжлэхээр байна.

Гадаад хүчин зүйлс, геополитикийн сөрөг нөлөө үргэлжилж байгаагаас инфляцын хүлээлт нэмэгдэх, хилийн хязгаарлалтаас шалтгаалан нүүрсний экспорт буурч, гадаад зах зээл дээрх үнийн өсөлттэй холбоотойгоор импорт нэмэгдэж, улмаар төлбөрийн тэнцлийн алдагдал өсөж байна. Иймд Мөнгөний бодлогын хороо инфляцын хүлээлтийг дунд хугацаанд тогтворжуулах, эдийн засгийн гадаад, дотоод тэнцвэрийг зохистой түвшинд хангах, гадаад суурь хүү өсөж буй орчинд төгрөгийн харьцангуй өгөөжийг хадгалах зорилгоор бодлогын хүүг өсгөх шийдвэрийг гаргав.

Цаашид эдийн засгийн сэргэлт, инфляцын өрнөл, нийлүүлэлтийн шинжтэй доголдол, олон улсын харилцааны нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдөхөөс хамаарч мөнгөний бодлогын дараагийн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Мөнгөний бодлогын хорооны хуралдааны хураангуй тэмдэглэлийг хоёр долоо хоногийн дараа Монголбанкны цахим хуудаст байршуулна.

МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХОРОО



04

ОНЦЛОХ МЭДЭЭ

АЛТНЫ СОРЬЦЫН
ХЯНАЛТЫН ҮЙЛ
АЖИЛЛАГААГ
ЦАХИМЖУУЛАВ



12

ЭДИЙН ЗАСАГ
ЭНГИЙНЭЭР

ТӨСВИЙН ДУНД
ХУГАЦААНЫ ТӨЛӨВ
БАЙДАЛ



19

АСУУЛТ, ХАРИУЛТ

МӨНГӨНИЙ
БОДЛОГЫН
ХОРООНЫ II
УЛИРЛЫН ШИЙДВЭР
ТАНИЛЦУУЛАХ
ХЭВЛЭЛИЙН БАГА
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ



35

ЗОЧИН

МӨНГӨНИЙ
БОДЛОГЫН ХОРООНЫ
ХАРААТ БУС ГИШҮҮД
ЮУ ХЭЛЭВ?



06

ЯРИЛЦЛАГА

Б.ЛХАГВАСҮРЭН:
ХҮЛЭЭЛТ
ЭВДЭГДЭХЭЭС
СЭРГИЙЛЖ
БОДЛОГЫН
ШИЙДЭМГИЙ АРГА
ХЭМЖЭЭГ АВЧ
БАЙНА



15

БАЙР СУУРЬ


МӨНГӨНИЙ
БОДЛОГЫН ХОРООНЫ
ШИЙДВЭРИЙН
ТАЛААР ЭДИЙН
ЗАСАГЧИД БАЙР
СУУРИА ИЛЭРХИЙЛЭВ



26

НИЙТЛЭЛ

ЭДИЙН ЗАСГИЙН
ӨСӨЛТ АВЛИГЫН
ХООРОНДОХ
ХАМААРАЛ



41

СУДАЛГАА

ГАДААД ХУДАЛДААНЫ
ТЭНЦЭЛ, ЭКСПОРТ,
ИМПОРТЫН ТОО
ХЭМЖЭЭ, ҮНЭ БОЛОН
ТАТВАРЫН ОРЛОГО
БҮРДЭЛТ

АЛТНЫ СОРЬЦЫН ХЯНАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЦАХИМЖУУЛАВ

2022/05/03



Монголбанк, Стандарт хэмжил зүйн газартай хамтран ажиллах гэрээг шинэчлэн байгууллаа. Уг гэрээг байгуулснаар иргэд, аж ахуйн нэгжүүд Монголбанканд алт, үнэт металл худалдахад Стандарт хэмжил зүйн газраас сорьцын баталгааг цахимаар авч, тоон гарын үсгээр баталгаажуулж байхаар боллоо. Үүгээр алт, үнэт металл тушаахтай холбоотой үйл ажиллагааг хялбаршуулж, цаг зардлыг бууруулах ач холбогдолтой юм. Монголбанк нь гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор дотоодын зах зээлээс үнэт металлыг Стандарт, хэмжил зүйн газрын сорьцын хяналтын газрын шинжилгээний дүнд үндэслэн худалдаж авдаг бөгөөд сүүлийн 5 жилийн хугацаанд 100 орчим тонн үнэт металл худалдан авч гадаад валютын албан нөөцийг 3.8 орчим тэрбум ам.доллараар нэмэгдүүлээд байна.

ФИТЧ АГЕНТЛАГ МОНГОЛ УЛСЫН ЗЭЭЛЖИХ ЗЭРЭГЛЭЛИЙН ҮНЭЛГЭЭГ "В", ТӨЛӨВИЙГ "ТОГТВОРТОЙ" ХЭВЭЭР ҮЛДЭЭСНИЙГ БАТАЛГААЖУУЛЛАА

2022/05/19



Фитч агентлаг Монгол Улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээг "В", төлөвийг "Тогтвортой" хэвээр үлдээснээ 2022 оны 5 дугаар сарын 18-ны өдөр зарлалаа. Тус байгууллагын дүгнэлтээр Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдлыг огтвортой байна гэж дүгнэжээ. Ингэж үзэхдээ Монгол Улсын засаглалын үзүүлэлтүүд, нэг хүнд ногдох орлого нь "В" түвшинтэй бусад орнуудтай харьцуулахад өндөр. Энэ оны бодит эдийн засгийн өсөлтийг 1.2% гэж таамаглажээ. Мөн ДНБ-ий өсөлтийг 2023 онд 6.3%, 2024 онд 6.8% хүртэл өснө гэж төсөөлсөн байна. Оюутолгой төслийн талаар Засгийн газар болон хөрөнгө оруулагч талуудын сүүлд байгуулсан гэрээ нь гадаадын хөрөнгө оруулагчдад болон далд уурхайн бүтээн байгуулалтыг үргэлжлүүлэхэд эерэгээр нөлөөлнө гэж үзжээ. Төсвийн алдагдлыг 2022 онд ДНБ-ийн 4.4% (В зэрэглэлтэй бусад улсуудын дундаж: 4.7%) болж өснө. Цаашид Монгол Улсын эдийн засаг сэргэх хандлагатай байгаа тул төсвийн орлого бүрдүүлэлт эрчимжсэнээр алдагдал 2023 онд 3.7% хүртэл буурна гэж төсөөлөв. Фитчээс Монгол Улсын урсгал тэнцлийн алдагдлыг 2022 онд ДНБ-ий 16.3%, гадаад өрийн үлдэгдэл ДНБ-ий 167%-д байна гэж төсөөлөв. Мөн гадаад валютын нөөцийг 2022 оны эцэс гэхэд 3.6 тэрбум ам. доллар байна гэж тооцоолсон байна.

МОНГОЛБАНКНЫ НЭРЭМЖИТ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАГА ХУРАЛ БОЛОВ

2022/05/26



Монголбанкнаас жил бүр зарладаг "Эрдэм шинжилгээний бага хурал" боллоо. Тус эрдэм шинжилгээний бага хурал нь эдийн засаг, статистик болон санхүүгийн чиглэлээр судалгаа, шинжилгээ хийдэг судлаач, эрдэмтэд, оюутнуудыг дэмжих, бүтээлийг нь нийтэд түгээн дэлгэрүүлэх, бодлого боловсруулахад оролцох оролцоог нь нэмэгдүүлэх зорилготой юм. Энэ жилийн хувьд тус хуралд ирүүлсэн бүтээлүүдийг 2 шатанд шалгаруулж, сүүлийн шатанд оюутан, судлаач гэсэн ангилал тус бүрт 5 бүтээлийг шалгаруулсан байна. Ангилал тус бүрийн тэргүүн байрд МУИС-ийн Эдийн засгийн тэнхимийн багш Б.Даваамаагийн "Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний хөдөлмөр эрхлэлтэд үзүүлэх нөлөөг хэмжих нь" МУИС-ийн Санхүүгийн тэнхимийн 4-р дамжааны оюутан Б.Батцэнгэлийн "IPO хийх банкуудын давамгайл тоглогчийг тодорхойлох нь" бүтээлүүд шалгарчээ.

МОНГОЛ-ХЯТАДЫН ЭДИЙН ЗАСАГ, ХУДАЛДААНЫ ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ОЛОН УЛСЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БАГА ХУРЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАВ

2022/06/21



Монгол Улсын ГХЯ, Монголбанк, ШУА, ЭЗХЯ, БНХАУ-аас Монгол Улсад суугаа ЭСЯ, МУХАУТ хамтран “Монгол-Хятадын эдийн засаг, худалдааны хамтын ажиллагааны өнөөгийн байдал, хэтийн төлөв” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгууллаа. Хурлыг нээж, Монгол Улсын Их хурлын даргын ахлах зөвлөх Д.Лүндээжанцан УИХ-ын дарга Г.Занданшатарын илгээлтийг оролцогчдод уншиж танилцуулав. Мөн Монгол Улсын гадаад харилцааны сайд Г.Батцэцэг, БНХАУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Цай Вэньруй, Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн, Монгол Улсын ШУА-ийн Дэд ерөнхийлөгч, академич Г.Чулуунбаатар, МУХАУТ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга С.Баясгалан нар үг хэлэв. Хурлаар Монгол Улс, БНХАУ-ын хоорондын худалдаа, эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагаа, хөрөнгө оруулалт, цаашдын чиг хандлага зэрэг сэдвээр 10 гаруй илтгэл тавьж, хэлэлцүүлэг өрнүүлээ. Оролцогчид дэлхий дахинд эдийн засгийн тодорхой бус нөхцөл байдал нэмэгдсэн энэ үед бодлого боловсруулагчид, эрдэмтэн судлаачид хоёр улсын хамтын ажиллагааны талаар өргөн хүрээтэй хэлэлцүүлэг өрнүүлж байгаа нь өндөр ач холбогдолтойг онцолж байв. Монгол Улс, БНХАУ хоорондын худалдаа, эдийн засгийн харилцаа, хамтын ажиллагаа өргөжсөөр байгаа бөгөөд 2021 оны эцсийн байдлаар гадаад худалдааны нийт бараа эргэлт 10.1 тэрбум ам.долларт хүрснээс экспорт 7.6 тэрбум ам.доллар, импорт 2.4 тэрбум ам.доллар байв.

ҮНДЭСНИЙ ТӨЛБӨРИЙН СИСТЕМИЙН ЗӨВЛӨЛИЙН ЭЭЛЖИТ ХУРЛААР ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГЫН ТАЛААР ХЭЛЭЛЦЭВ

2022/06/22



Тус хурлаар “Монгол Улсын төлбөрийн системийг хөгжүүлэх дунд хугацааны стратеги”-ийн талаар танилцуулав. Монголбанк нь 2009 оноос эхлэн Монгол Улсын үндэсний төлбөрийн системийг хөгжүүлэх дунд хугацааны стратегийг таван жил тутамд батлан, хэрэгжүүлж ирсэн. Энэ удаа гурав дахь стратегийн баримт бичгийн төслийг боловсруулж, мөрдөн ажиллахад бэлэн болгоод байна. Тус стратегид 2026 он гэхэд Монгол Улсад өрсөлдөөн, инновацид тулгуурласан, хүртээмжийг нэмэгдүүлж, эрсдэлийг бууруулсан, найдвартай, аюулгүй ажиллагааг бүрэн хангасан дэд бүтцээр дамжуулан төлбөр тооцоог гүйцэтгэж, төлбөр тооцоог улам бүр дижитал болгох зорилтыг дэвшүүлээд байна. Мөн үеэр энэ онд хэрэгжүүлэн дуусч байгаа АХБ-тай хамтарсан “Төлбөрийн системийн шинэчлэл төсөл” төслийг хүрээнд хийж гүйцэтгэсэн ажлыг нэгтгэн танилцууллаа. Төслийн хүрээнд төлбөрийн системийн суурь дэд бүтэц болох банк хоорондын төлбөр тооцооны Автомат клиринг хаус, Төлбөрийн картын систем, Төв банкны үндсэн бүртгэлийн системийг шинэчилсэн зэрэг ач холбогдол бүхий томоохон ажлуудыг хийж гүйцэтгээд байна. Эцэст нь геополитикийн нөхцөл байдалтай холбоотойгоор ОХУ руу хийх төлбөр тооцоонд үүсэж байгаа хүндрэл болон тулгамдаж байгаа цаг үеийн асуудлыг шийдвэрлэх боломжийн талаар хуралд оролцогчид хэлэлцлээ.

ХҮЛЭЭЛТ ЭВДЭГДЭХЭЭС СЭРГИЙЛЖ БОДЛОГЫН ШИЙДЭМГИЙ АРГА ХЭМЖЭЭГ АВЧ БАЙНА

Монголбанкны
Ерөнхийлөгч
Б.Лхагвасүрэнтэй
эдийн засгийн
нөхцөл байдлын
талаар ярилцав.



Анх ажлаа авч байх үетэй харьцуулахад таны харж байгаагаар өнөөдөр эдийн засаг, бизнесийн орчин хэр их өөрчлөгдсөн бэ. Үүнээс ярилцлагаа эхэлье.

Монгол банкны Ерөнхийлөгчөөр 2019 оны сүүлээр томилогдоод гурван том зорилт, арга хэмжээг яаралтай авч хэрэгжүүлнэ гэж олон нийтийн мэдээллийн хэрэгслэлд болон Улсын Их Хурлын байнгын хороон дээр танилцуулж байснаа тод санаж байна. Монгол Улс 2019 оны 10 сард Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын “саарал” жагсаалтад

бүртгэгдсэн байсан учир юуны өмнө тус байгууллагын зөвлөмж болон хэрэгжилтийн ажлыг богино хугацаанд хэрэгжүүлж тус жагсаалтаас гаргах, мөн 2017 оноос хэрэгжүүлж эхэлсэн хэдий ч зогсонги байдалд ороод байсан Олон Улсын Валютын Сан (ОУВС)-ийн 3 жилийн хугацаатай “Өргөтгөсөн санхүүжилтын хөтөлбөр”-ийг амжилттай дуусгах, улмаар эдийн засгийн сэргэлтийг цаашид хадгалах, макро эдийн засгийн үзүүлэлтүүдийг тогтворжуулж ажиллахаар зорьсон. Тодорхой үр дүнгүүд ч богино хугацаанд гарсан. Тухайлбал, нэг жил

хүрэхгүй богино хугацаанд “саарал” жагсаалтаас гарч чадсан, ОУВС-ийн хөтөлбөрийг амжилттай дуусгаж, зарим нэг арга хэмжээ буюу банкны салбарын шинэчлэлийг өөрсдөө бие даан үргэлжлүүлэхээр болж, өнөөдөр банкууд олон нийтийн оролцоо, хяналттай болоход бэлэн болоод байна. Олон ажлын ард амжилттай гарч байгаа хэдий ч хүндхэн хэд хэдэн том сорилтуудтай нүүр тулан ажиллаж ирлээ. 2020 он дөнгөж эхлээд дэлхий нийтийг хамарсан цар тахал дэгдэж, хорио цээрийн дэглэмүүд их бага хэмжээгээр тавигдаж, тээвэр, ложистикийн

гацалт, хил боомт дээрх саатал, хязгаарлалт үүсэж зарим нь өнөөдрийг хүртэл үргэлжилсээр байна. Монгол Улс КОВИД-19 цар тахлын дараах сэргэлттэйгээ дөнгөж золгох гэж байтал энэ оны 2 сарын сүүлээс эхлэн Украин дахь дайн, түүнээс улбаатай эдийн засаг, санхүүгийн хориг арга хэмжээнүүд гээд олон улсын тавцанд хурцадмал байдал бий болж, бидний хувьд дараагийн нэмэлт сорилттойгоо нүүр тулаад байна. Цар тахал, өнөөгийн геополитикийн хурц байдлыг хэн ч урьдчилан таамаглах аргагүй зүйл тул сүүлийн 2 жил дэлхий даяар том шоктой, зөвхөн эдийн засаг төдийгүй бүхий л талаар сорилтын жилүүд байсан гэж хэлж болно. 2022 онд олон улс орон өндөр инфляц, эдийн засгийн зогсонги байдал, нийлүүлэлтийн сүлжээний тасалдал зэрэг нийтлэг сорилтуудтай тулгарч байна. Гэхдээ эдгээр сорилт нь хүн төрөлхтний сэтгэлгээ, хөгжилд томоохон шинэчлэлтийг авчирч хүмүүсийн ажиллаж амьдрах хэв маяг, бизнесийн үйл ажиллагаа, бодлого боловсруулалтын түвшинд ихээхэн өөрчлөлтийг бий болголоо. Ногоон шилжилт, цахимжилт, зайнаас ажиллах гээд олон жишээг дурдаж болно.

Төв банк яагаад оны өмнөх эдийн засгийн төсөөллөө 2 дахин бууруулахад хүрэв?

2021 оны 12-р сарын төсөөллөөр эдийн засгийн өсөлт 2022 онд 5.5%-д хүрнэ гэж төсөөлж байсан бол энэ оны 4 дүгээр сард гаргасан Инфляцын

тайландаа бид төсөөллөө бууруулж 2.4% болгосон. Үүнд нэг талаас эдийн засгийн идэвхжил хүлээлтээс доогуур байсан, мөн гадаад орчны эрсдэл эрс нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн. Тухайлбал, БНХАУ дахь цар тахлын тархалт, хөл хорионы нөлөө, хил дээрх хязгаарлалт хүлээж байснаас төвөгтэй нөхцөл байдалд үргэлжилж байна. Мөн ОХУ-Украины асуудал хүлээж байгаагүй том шок үүсгэлээ. Эдгээр шокууд нь зах зээлд оролцогчдын хүлээлт, гадаад зах зээлтэй холбогдох холбоосоор дамжаад хэрэглээ, хөрөнгө оруулалт, гадаад худалдааны аль алинд нь сөргөөр нөлөөлж байна. Үйлдвэрлэл талаас авч үзвэл, экспортын гарц, дотоодын бүтээгдэхүүний импортын орц дээр саатал учруулснаар уул уурхайн болон уул уурхайн бус салбаруудын өсөлт саарах эрсдэл үүсгэлээ. Монгол Улсын өөрийнх нь онцлог байдал мөн томоохон нөлөөтэй гэж үзэж болно. Манай экспортын 80-90 хувь өмнөд хөрш буюу БНХАУ руу гардаг бол, импортын 35, 30 хувь нь харгалзан БНХАУ, ОХУ-аас орж ирдэг. Урд хил, боомт дээрх хязгаарлалтаас үүдэлтэйгээр нүүрсний экспорт хэвийн хэмжээнд хүрэхгүй, импортын орцын нийлүүлэлтэд доголдол үүсэж байгаа бол олон улсын хориг арга хэмжээнээс улбаатайгаар хойд хөршөөс орж ирэх шатахуун тослох материал, бусад үйлдвэрлэлийн орцуудын үнийн өсөлт, хязгаарлалтууд нь эдийн засгийн эмзэг байдлыг

улам нэмэгдүүлж байна.

Дэлхийн бусад улс орнуудын хувьд ч цар тахал, геополитикийн шокоос шалтгаалж эдийн засгийн өсөлт саарах, цаашдын төлөв нь буурах хандлагатай байна. Олон улсын судалгааны байгууллагууд оны өмнө Монголын эдийн засгийн өсөлтийг 2022 онд 5%-6% орчимд төсөөлж байсан бол одоо төсөөллөө бууруулж 1%-3% хооронд гэж тооцож байна.

-Төв банк дотоодын эдийн засгаа хэрхэн харж, одоо ямар бодлого хэрэгжүүлж байна вэ?

Манай эдийн засаг нь дэлхий дахинд нөлөөлж буй шокуудаас ангид бус, бусад улс орнуудын адилаар эсвэл зарим тохиолдолд сөрөг нөлөө нь хүчтэй мэдрэгдэж байна. Монголбанк аль ч үед хуулиар хүлээсэн зорилтуудаа биелүүлэхэд чиглэсэн бодлогыг хэрэгжүүлдэг. Энэ нь үнийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн тогтвортой байдлыг хадгалахад чиглэсэн бодлого, арга хэмжээг хэрэгжүүлж байгаа гэсэн үг юм.

Гэхдээ өнөөдөр Монголбанкны хувьд бодлогын маш төвөгтэй сонголтуудтай нүүр тулж, шийдвэрээ гаргаж байна. Зөвхөн манай төв банк ч биш олон улсын төв банкууд төвөгтэй сонголттой нүүр тулж байгааг олон улсын мэдээллээс анзаарч болно. Өндөр инфляц үргэлжилсээр байгаа энэ цаг үед бодлогын хүүгээ өсгөж инфляцтай тэмцэх үү, цар тахлын хүнд үеэс дөнгөж сэргэж байгаа эдийн засгаа сэргээхэд дэмжлэг

үзүүлэх үүднээс хүүгээ одоогийн түвшинд хадгалах уу гэсэн хэцүү даалгавартай байгаа. Бидний хувьд инфляц нам дор байсан үед цар тахлын хүндрэлээс эдийн засгаа сэргээхэд гол анхаарлаа хандуулж байсан. Харин одоо импортын бараа, дэлхийн зах зээл дээрх нефтийн үнээс голлон шалтгаалж инфляц харьцангуй өндөр түвшинд хүрсэн тул хүлээлт эвдэгдэхээс сэргийлж бодлогын шийдэмгий арга хэмжээг авч байна. Бодлогын хүүгээ 2.5 нэгж хувиар огцом нэмэгдүүлж 9 хувьд хүргэлээ. Банкны салбарт шинэтгэлийн хөтөлбөрийг үргэлжилж, салбарын тогтвортой байдлыг бэхжүүлэхэд төвлөрч байна. Цар тахлын үед үзүүлж байсан хөнгөлөлт, чөлөөлөлтийг аажмаар буюу хэсэгчлэн бууруулсаар зохицуулалтууд хэвийн хэмжээндээ бүрэн эргэж ирсэн. Мөн хууль эрх зүйн орчин, банкны засаглал, хяналт шалгалт болон зохицуулалтын арга хэрэгслийг улам сайжруулах, технологийн дэвшлийг нэвтрүүлэх олон ажлыг хэрэгжүүлж эхлүүлээд байна. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог бэхжүүлэхэд ч банкны салбар чухал үүрэгтэй тул шаардлагатай арга хэмжээнүүдийг цаг алдалгүй авч хэрэгжүүлж байна.

Мөнгөн тэмдэгт, төлбөр тооцоо гээд төв банкны бусад үйл ажиллагаан дээр ч технологийн сайжруулалт, дэвшлүүд тасралтгүй хийгдэж байгааг дурдах нь зүйтэй.

Иргэдийн зээлийн хэмжээ ААН-ын зээлээс давсан байсан.

Арилжааны банкны зээл олголт, зээлийн чанар ямар түвшинд байна вэ?

Ковидын эхэн үе буюу 2020 онд банкны зээл огцом буурч байсан бол одоо банкны салбарын тогтвортой байдал хадгалагдаж, санхүүгийн зуучлал хэвийн үргэлжилж байна. 2022 оны 4 дүгээр сарын статистик мэдээгээр иргэдийн зээлийн үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 32.3% өсч 11.6 их наяд төгрөгт хүрсэн бол, байгууллагын зээлийн үлдэгдэл 28.5% өсч 10.5 их наяд төгрөгт хүрчээ. Зээл олголтыг авч үзвэл өнгөрсөн 4-р сард л гэхэд 2 их наяд 968 тэрбум төгрөгийн зээл олгосноос иргэд болон байгууллагад олгосон зээлийн харьцаа бараг тэнцүү байна. Иргэдийн зээлийн бүлгийг нарийн шалгаж үзвэл иргэд зөвхөн хэрэглээндээ зориулж зээл авахаас гадна хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэд жижиг, бичил бизнесийн чиглэлээр авч ашигладаг хэмжээ багагүй хэмжээнд хүрсэн тоо баримт байгаа. Банкны салбараас олгосон нийт зээл ДНБ-ний 50 гаруй хувьтай тэнцэж байгаа нь бодит секторыг дэмжих, сэргээх санхүүжилтийн гол эх үүсвэр нь банкны салбараас олгож байгаа зээл болохыг харуулж байна. Чанаргүй зээл нийт зээлийн 9.4%-д хүрч байгаа нь сүүлийн 4 жилийн хамгийн доогуур үзүүлэлт юм.

Банкны хувьцааны төвлөрлийг задлах, олон нийтэд нээлттэй болгох, IPO гаргах санаачилгын авторуудын нэг нь Таныг гэж

сонсож байсан. Арилжааны банкуудад санхүүгийн тайланд Монголбанк шалгалт хийгээд эхэлчихсэн үү?

Санхүүгийн зах зээл, банкны тогтолцооны тогтвортой байдлыг хангах нь Монголбанкны хуулиар ногдсон үүрэг байдаг. Банкыг нээлттэй хувьцаат компани болгох, хувь эзэмшлийн төвлөрлийг бууруулах замаар илүү эрүүл, найдвартай, ил тод, олон нийтийн хяналттай банкны системтэй болгохоор зорин ажиллаж банкны салбарын шинэтгэлийн хөтөлбөр гаргаж банкны тухай хуульд нэмэлт өөрчлөлтүүд оруулаад байна.

Ердийн үед зайны болон газар дээрх хяналт шалгалтыг Монголбанк тогтмол хийж ирсэн. Банкны салбар олон давхар хяналт шалгалттай, маш хатуу нарийн зохицуулалттай салбар. Дэлхийд танигдсан нэр хүнд бүхий хөндлөнгийн аудитын компаниар санхүүгийн тайлангаа үнэлүүлдэг жишигтэй болоод мөн томоохон банкууд маань олон улсын зэрэглэл тогтоох байгууллагуудаар улстайгаа зэрэгцээд зэрэглэлээ тогтоолгодог болоод удаж байна. Дээр нь нэмээд хувьцаагаа олон нийтэд гаргахдаа активын чанарын үнэлгээг хөндлөнгийн, олон улсад нэр хүнд бүхий компаниар хийлгэх нь гадна дотны хөрөнгө оруулагч нарыг итгэлийг нэмэгдүүлэх эерэг нөлөөтэй гэдэг талаас нь олон улсын санхүүгийн байгууллагуудын өгсөн зөвлөмжийг үндэслэн нээлттэй

сонгон шалгаруулалт зарлаж, гэрээ байгуулан ажлыг эхлүүлээд байна. Үнэлгээний үр дүнг энэ оны 7-8 сард багтаагаад гаргах төлөвлөгөөтэй ажиллаж байгаа.

Инфляцын энэ оны төсөөлөл ямар байна вэ. Тодорхой бус, нийлүүлэлтийн гаралтай гаралтай инфляцын дарамт 2022 оны турш үргэлжлэхээр байна уу?

Ковид-19, экспортын саатал, геополитикийн хурцадмал байдал зэрэг нь манай эдийн засагт гадаад зах зээлтэй холбоос (худалдаа, төлбөр тооцоо гм) болон зах зээлд оролцогчдын хүлээлт зэрэг сувгуудаар дамжин нөлөөлж эдийн засгийн идэвхжил саарлаа. Олон улсын зах зээл дээрх хүнс, газрын тосны үнийн өсөлт, тээвэр ложистикийн асуудлууд бий. Манай орны хувьд цөөхөн хэдэн бараа бүтээгдэхүүний үнийн савлагаа болон төрийн зохицуулалттай зарим нэг бараа бүтээгдэхүүний үнийн хөнгөлөлт чөлөөлөлтийг арилгасан шийдвэрээс улбаалсан үнийн өсөлт голлох нөлөөллийг үзүүлж байна.

Өнгөрсөн 3-р сарын төсөөллөөр 2022 оны туршид инфляц харьцангуй өндөр түвшинд байх ч 2023 онд тогтворжиж, Төв банкны зорилтот түвшинд хүрч буурах төсөөлөлтэй байсан. Харин энэ 6 дугаар сарын Мөнгөний бодлогын хорооны ээлжит хурлаар инфляцын төсөөллөө шинэчилэх хүлээж байна хэдий ч төсөөлөл маань хэвээрээ байх болов уу.

Сүүлийн 2 сард инфляцын хурдац нь саарч, бага зэрэг түвшингээрээ буурч эхэлсэн нь нааштай үр дүн юм. Инфляцын сүүлийн статистикийг авч үзвэл 60% орчмыг нь импортын бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт бүрдүүлсэн байна. Өөрөөр хэлбэл 4-р сарын 14.4% өсөлтийн 8.1 нэгж хувь нь гаднаас авдаг зарим төрлийн хүнс, бараа, шатахуун зэрэг бараа, бүтээгдэхүүний нөлөөлөл өндөр байна.

Мөнгөний бодлогын хороо энэ оны 1-р улиралд үнийн түвшний өсөлт эрчимжсэн нөхцөлд инфляцын цаашдын хүлээлт эвдэгдэхээс сэргийлж бодлогын хүүг нэлээд огцом өсгөж, дунд хугацаанд тогтворжуулах зорилгоор шийдэмгий арга хэмжээг авсныг Та бүхэн сайн мэдэж байгаа. Цаашид ч Монголбанк инфляцыг зорилтот түвшинд хүргэх чиглэлд бодлогын бүх арга хэрэгслээ ашиглах болно. Харин төв банкны арга хэрэгслээр нөлөөлөх аргагүй үнийн өсөлт дээр УИХ, Засгийн газраас бараа бүтээгдэхүүний нөөц бүрдүүлэх, үнийн огцом савлагаанаас сэргийлэх арга хэмжээг авч байгаа нь үр дүнгээ өгнө гэдэгт итгэлтэй байна.

Төгрөгтэй харьцах ам.долларын ханш үндсэндээ тогтворжсон гэж ойлгож болох уу. Валютын ханшийн эрсдэлийг хэрхэн тооцож байна вэ?

Валютын ханш дээр өнгөрсөн 3-4 сард олон улсын хурцадмал нөхцөл байдлаас үүдэлтэй түр

зуурын савлагаа ажиглагдаад 5-р сард тогтворжоод байна. Үүнийг зах зээлд оролцогчдын хүлээлтээр голлон өдөөгдсөн, мөн гадаад орчны эрсдэл, экспортын саатал нөлөөлсөн гэж тайлбарлаж болно. Тухайн үед төлбөрийн тэнцэл дээр тодорхой дарамтууд байсан ч Монголбанк огцом савлагаа үүсэхээс сэргийлэх хэмжээний гадаад валютын нөөцтэй байсан. Нэгэнт экспортын бууралттай холбоотойгоор валютын орох урсгал дээр саатал үүссэн тул ханш дээр тодорхой хэмжээний тохиргоо хийгдэх шаардлага бол зүй ёсоор гарч ирсэн. Ханшын тохиргоо хийгдсний үр дүнгээр бид валютын нөөцөө хамгаалж үлдэх боломжтой. Гадаад орчны эрсдэл хэр удаан үргэлжлэх эсэх нь тодорхой бус үед валютын нөөцөөс гадна ханш өөрөө гадаад сөрөг шокыг шингээгчийн үүргийг гүйцэтгэхгүй бол 2016 оны сургамж давтагдах эрсдэл бий. Евро, фунт стерлинг, йен гээд дэлхийн нөөцийн голлох валютууд хүртэл сүүлийн 1 жилийн хугацаанд 2 оронтой тоогоор суларч, олон улсын зах зээл савлагаа ихтэй байгааг бүгд харж байна. Гэхдээ нөгөө талаас, экспортын гацаа л арилчихвал зэс, нүүрс, алт зэрэг манай экспортын гол бүтээгдэхүүнүүдийн үнэ түүхэн өндөр түвшинд байгаа нь бидэнд боломж байгааг илтгэнэ. Төлбөрийн тэнцэл дээрх дарамтууд богино хугацаанд шийдвэрлэгдэх боломжтой гэж харж байна.

Улсын гадаад валютын албан нөөц одоо хэд байгаа вэ. Нөөц нэмэгдэх хүрээнд Төв банк хэрхэн ажиллаж байна вэ?

Валютын нөөц эны оны 5 сарын сүүлийн байдлаар 3.1 тэрбум ам.доллар байгаа нь 6 сарын импортын хэрэгцээг хангахад хангалттай түвшинд байна. Төв банк валютын нөөцийг нэмэгдүүлэхэд онцгойлон анхаарсаар ирсэн, өмнөд хөршийн “Тэг ковид” гэсэн маш хатуу бодлогын өмнө манай нөөц түүхэн дээд хэмжээ 5 тэрбум ам. доллараар хэмжээнд хүргэж нөөц бүрдүүлсэн нь сүүлийн 2 жилийн хүчтэй сөрөг шокуудыг даван туулахад чухал үүрэг гүйцэтгэж, төгрөгийн ханш харьцангуй тогтвортой байхад нөлөөлсөн. Төв банкны хувьд, экспортлогч аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллах, мөн алт худалдан аваалтаа нэмэгдүүлэх замаар нөөцийг нэмэгдүүлэх арга хэмжээг авч ажиллаж байна. Боломжууд байгааг ч би түрүүн онцолсон.

Алт олборлолтыг нэмэгдүүлэх, улмаар алт тушаалтыг ахиулах чиглэлд Монголбанк ЗГ хамтран ажиллаж ирсэн. Алт 2 хөтөлбөрийн үр дүн өнгөрсөн онд ямар байсан бэ. Алтны тушаалт энэ онд нэмэгдэх боломжтой юу?

Монголбанк 2021 онд 21 тонн үнэт металл худалдан авсан бол энэ онд 24 тоннд хүргэх зорилт тавин ажиллаж байна. Алт худалдан авалтаар дамжуулж бид валютын нөөцийг жил бүр

800 саяас 1 тэрбум ам.доллараар нэмэгдүүлдэг.

Цар тахлын тухай хууль (Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль)-ийн хүрээнд алт тушаалтыг нэмэгдүүлж, валютын нөөцийг бүрдүүлэх зорилгоор Засгийн газартай хамтран ажиллаж байгаа. Алт-2 үндэсний хөтөлбөрийг эрчимжүүлэх ажлын хүрээнд 2020 оны 6 дугаар сараас эхлэн алт олборлогч аж ахуйн нэгжүүдийн хүчин чадлыг нэмэгдүүлэх, эргэлтийн хөрөнгийг санхүүжүүлэх зорилгоор арилжааны банкаар дамжуулан санхүүжилтийн эх үүсвэрийг олгож эхэлсэн.

Түүнчлэн, өнгөрсөн 4 дүгээр сард УИХ-аас баталсан хууль (Гол нэр төрлийн бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомсдолоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль)-ийн дагуу Лондонгийн металлын захын өмнөх ажлын өдрийн хаалтын үнэ дээр 5 хувийг нэмсэн ханшаар дотоодын зах зээлээс үнэт металл худалдан авч эхэлсэн нь иргэд, аж ахуйн нэгжүүдийн алт тушаалтыг нэмэгдүүлнэ гэж хүлээж байна. Оюу толгойн хүдрийн баяжмалыг дотооддоо цэвэршүүлэн алт. зэсээр ялган боловсруулж эхэлбэл манай алт худалдан авалтын хэмжээ үлэмж нэмэгдэхийн зэрэгцээ нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүнээр дамжин ДНБ өсөх эерэг үр нөлөөтэй.

ГШХО энэ онд сэргэхээр байна уу. Төв банкны харж байгаагаар зөвхөн энэ оны хувьд гаднаас хэдий хэмжээний валютын урсгал манайх руу орж ирэхээр байна вэ?

Монгол Улсад орох ГШХО-ын орох урсгал энэ онд 1.7 орчим тэрбум ам доллар байхаар төсөөлж байна. Засгийн газар, Рио Тинтотой 2021 оны эцэст байгуулсан хэлэлцээрийн хүрээнд “Гүний уурхайн ашиглалтад орох хүртэлх шаардлагатай нэмэлт зардлыг Рио Тинто бүрэн хариуцах”-аар тохиролцсон нь Оюу толгой компани гүний уурхайн санхүүжилтээ ГШХО-оор бус бусад хөрөнгө оруулалт хэлбэрээр оруулж ирэхээр болсон. Гүний уурхайн бүтээн байгуулалт бүрэн хэрэгжиж, үйлдвэрлэл бүрэн хүчин чадлаараа ажиллах хугацаа улам бүр ойртсоор байгаа. Одоохондоо Оюу толгойн хөрөнгө оруулалтаас өөр дорвитой хөрөнгө оруулалт орж ирээгүй байгаа хэдий ч, Засгийн газрын шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд томоохон төслүүдийн хүрээнд хөрөнгө оруулалт орж ирэх боломж, үүд хаалга нээлттэй байгаа бөгөөд ойрын ирээдүйд жилдээ 4-5 тэрбум доллараар орж ирж байсан өмнөх жилүүдийн таатай орчин нөхцөл дахин бүрэлдэнэ гэдэгт эргэлзэхгүй байна.

Гадаадын хөрөнгө оруулалтын урсгал уул уурхайгаас гадна өөр ямар салбарт ихэвчлэн хийгдэж байна вэ?

Гадаадын шууд хөрөнгө оруулалтын 90 орчим хувь нь уул уурхай, худалдаа, санхүү даатгалын салбарт ордог. Тухайлбал, гадаадын шууд хөрөнгө оруулалтын үлдэгдлийг 2021 оны байдлаар эдийн засгийн салбараар авч үзвэл уул уурхайд нийт ГШХО-ын 75% нь ногдож байна. Үүний дараагаар уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэх гол түүхий эд болох газрын тос, уул уурхайн бүтээн байгуулалтын тоног төхөөрөмж худалдах худалдааны салбар гадаадын хөрөнгө оруулагчдын хөрөнгө оруулалтын 7 хувийг эзэлж байна. Санхүү даатгалын салбарт ГШХО-ын 5 орчим хувь нь ногддог мэдээ бий. Монгол улсын хүн ам бусад зах зээлтэй харьцуулахад их биш гэдэг утгаар сайн зах зээл биш ч хоёр томоохон зах зээлийн дунд оршдог, байгаль цаг уурын нөхцөлийн хувьд сэргээгдэх эрчим хүч, ногоон хөгжил, тусгай аялал жуулчлал болон цахим хөгжлийн суурь дэд бүтэцийг хөгжүүлэх давуу тал боломжуудаараа гадаадын хөрөнгө оруулагчдыг татах бүрэн боломжтой гэж хардаг.

Монгол банкны Ерөнхийлөгчийн хувьд гадаад, дотоодын хөрөнгө оруулагч нарт хандаж юу гэж хэлэх вэ?

Аль ч хөрөнгө оруулагчийн сонирхож, анхаардаг нэг чухал зүйл бол мэдээж хөрөнгө оруулалтынх нь өгөөж юм. Монгол Улсын дунд, урт хугацааны эдийн засгийн төлөв эерэг, өсөлтийн

потенциаль өндөр тул үүнийг дагаад өгөөж байна гэсэн үг. Үүнийг олон улсын санхүүгийн байгууллагууд, зээлжих зэрэглэл тогтогчид бүгд хэлж байгаа. Иймд гагцхүү богино хугацааны эрсдэлийг хэрхэн удирдах вэ гэдэг чухал асуудал болж байна. Төв банкны зүгээс макро эдийн засгийн тогтвортой байдлыг бүрдүүлэхэд хувь нэмрээ оруулах, үүний хүрээнд үнийн тогтвортой байдал болоод банкны салбарын тогтвортой байдлыг бэхжүүлэхэд бүх арга хэрэгсэл, хүчин чармайлтаа дайчлан ажиллаж байгаа цаашид чөөрийн нөөц бололцоог бүрэн дайчлан болно. Мөн төв банк эдийн засгийн эрсдэлийг хэрхэн харж байгаа, түүнийг шийдвэрлэх чиглэлд ямар бодлого хэрэгжүүлэхээ зах зээлд оролцогчидтой ил тод, нээлттэй хуваалцаж байгаа нь итгэлийг нэмэгдүүлэх болов уу. Монгол улс хөрсөн дороо өвлөгдөж ирсэн түүхий эдийн арвин нөөц баялагаас гадна жил бүр шинээр бий болдог малын гаралтай түүхий эдийн болоод сэргээгдэх эрчим хүчний томоохон эх үүсвэрийн боломжтой, дээр нь маш залуу үндэстэн гэдэг талаасаа орчин үеийн чиг хандлагад нийцэх олон давуу талууд бидэнд бий гэж хардаг. Олон улсын нийлүүлэлтийн болон өртгийн сүлжээнд холбогдвол нөөц боломж илүү их бүрдэх болно.

Бид хөрөнгө оруулалт, бизнес, эдийн засгийн орчныг сайжруулахын тулд цаашид юу хийх нь чухал вэ?

Нэгт, урт хугацааны хөгжил бүтээмжээс эхэлнэ. Иймд бүтээмжийг сайжруулах бүтцийн бодлого чухлаар тавигдана. Бүтээмж өндөртэй газар л хөрөнгө оруулалт хийх сонирхол их, бизнесүүд ч олноор бий болно шүү дээ. Хоёрт, бизнесийн цикл мэдээж өсөлттэй, уналттай. Сайн төрөлжиж амжаагүй эмзэг бүтэцтэй манай эдийн засгийн хувьд тогтворжуулах бодлого гол үүрэг гүйцэтгэх тул бодлогын зохистой хослол, сахилга бат зайлшгүй чухал. Гуравт, төр - хувийн хэвшлийн оновчтой хамтын ажиллагаа зайлшгүй шаардлагатай. Эдгээрт шаардлагатай институц, технологи, мэдлэгийн тогтолцоог бэхжүүлэх нь чухал. Цар тахлын болон олон улсын хурцадмал байдлын хүнд сорилтууд бидний эмзэг байдлыг харуулж ойлгуулсан, ойлгосон гэдэг утгаараа УИХ, Засгийн газраас Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд гаргаж байгаа шийдвэр, арга замаа зөв тодорхойлсон тул гадаад дотоодын хөрөнгө оруулагч, хөгжлийн түншүүдтэйгээ бүх талын хамтын ажиллагаа ойртуулан тогтвортой байдлаар хамтран ажиллах нь зөв гарц, шийдэл байх болов уу.

Ярилцсанд баярлалаа.



МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН ДУНД ХУГАЦААНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ

1. МОНГОЛ УЛСЫН 2023-2025 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ТӨСӨӨЛӨЛ



1.1 Монгол Улсын 2023-2025 оны төсвийн орлогын төсөөлөл

Монгол Улсын 2023-2025 оны төсвийн орлогын төсөөллийг Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль, макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн төсөөлөлд тулгуурлан боловсрууллаа.

Төсвийн нийт орлогын дүн /тэрбум төгрөг/

Үзүүлэлт	2023 төс	2024 төс	2025 төс
Тэнцвэржүүлсэн орлого	17,312.2	18,511.9	20,074.8

Эх үүсвэр: Сангийн яам

Монгол Улсын Засгийн газраас эдийн засгаа тэлж, төсвийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг үргэлжлүүлэн, боомтын шинэчлэлийн ажлыг эрчимжүүлж, гадаад худалдааны эргэлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлого хэрэгжүүлж байна.

Түүнчлэн, Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын нөлөөний дараа дэлхийн эдийн засаг сэргэж, олон улсын зах зээл дээрх зэсийн үнийг тонн тутамд 9,300 орчим ам.долларт хэлбэлзэхээр тооцлоо. Ингэснээр, Монгол Улсын төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2023 онд 17.3 их наяд төгрөг, 2024 онд 18.5 их наяд төгрөг, 2025 онд 20.0 их наяд төгрөгт хүрэхээр байна.



1.2 Төсвийн зарлагын чиглэлээр

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлнэ. Дэлхий нийтийг хамарсан Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас шалтгаалан үүссэн эдийн засгийн хүндрэлийн үед бүх шатандаа хэмнэлтийн бодлого баримталж төсвийн бүх шатны байгууллагууд “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол, “Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2022 оны 388 дугаар тогтоолыг тус тус мөрдөн ажиллаж байна.

Төсвийн хэмнэлтийн хүрээнд төрийн байгууллагуудын гадаад, дотоод албан томилолт, зочин төлөөлөгч хүлээн авах, тавилга, эд хогшил, ном хэвлэл худалдан авах, сурталчилгаа хийх, бэлэг дурсгалын зүйлс бэлтгэх, уралдаан тэмцээн, тэмдэглэлт ой, баяр ёслолын арга хэмжээ зохион байгуулах, автомашин худалдан авах, захиргааны байгууллагуудад засвар тохижилт хийх болон бичиг хэргийн зардлын санхүүжилтийг түр хойшлуулах болон бууруулах арга хэмжээ авч байна.

Хэдийгээр Засгийн газраас эдийн засаг, нийгмийн цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан төсвийн зарлагын өсөлтийг хязгаарлах, төсвийн тэнцлийг сайжруулах зорилгоор төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай шийдвэр удаа дараа гаргаж ирсэн боловч зөвхөн тухайн санхүүгийн

жилд хэрэгжиж цаашид тогтвортой мөрдөгдөхгүй байхын зэрэгцээ төсвийн байгууллагуудад тэгш бус үйлчилж ирсэн байна.

Хэмнэлтийг зөвхөн төсвийн байгууллагуудад цаг үеийн шинжтэй байдлаар хэрэгжүүлэх бус харин үндэсний хэмжээнд нэгдсэн байдлаар, улсын салбарын бүх хуулийн этгээд, албан тушаалтныг хамруулж, байнгын шинжтэй хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага үүсээд байна.

Иймд төрийн бүх шатанд санхүүгийн сахилга батыг мөрдүүлэн ил тод байдлыг хангах, үр ашгийг

нэмэгдүүлэх, үрэлгэн байдлын эсрэг хязгаарлалт тогтоох, хяналт тавих зорилгоор Засгийн газраас 2022 оны төсвийн тодотголтой хамт өргөн мэдүүлсэн Төрийн хэмнэлтийн тухай хуулийн төслийг Улсын Их Хурал хэлэлцэн батлаад байна.

Хэмнэлтийн горимыг байнгын шинжтэй мөрдөж хэрэгжүүлснээр төрийн бүх шатанд үрэлгэн байдал арилж, төсвийн зарцуулалтын үр ашиг сайжрах, төсвийн зарлагын өсөлт дунд болон урт хугацаанд буурах ач холбогдолтой байх болно.



УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨӨЛӨЛ 2023-2025 ОНД:

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2023-2025 онд шинээр хэрэгжүүлэх төслүүдийг үр ашиг, эрэлт хэрэгцээнд тулгуурлан ач холбогдлоор эрэмбэлэх, эхлүүлсэн төслүүдийг үргэлжлүүлэх дуусгахад чиглэсэн хөгжлийн хөрөнгө оруулалтын бодлого баримтална. Үүнд:



ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРТ

Иргэд эх орондоо оношлогдон, эмчлүүлэх боломжийг нэмэгдүүлэх, эмнэлгүүдийн барилга байгууламж, дэд бүтцийг сайжруулах, тэгш хүртээмжтэй, чанартай үйлчилгээг үзүүлэх орчныг бүрдүүлнэ.



БОЛОВСРОЛЫН САЛБАРТ

Суралцагчдад ээлтэй сургалтын орчныг бүрдүүлж, хүртээмжийг нэмэгдүүлэх, тусгай хэрэгцээт хүүхдийг ердийн сургууль, цэцэрлэгт сурах, хөгжих боломжийг нэмэгдүүлнэ.



ТӨВЛӨРЛИЙГ СААРУУЛАХ БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Төвлөрлийг сааруулах бодлогыг хэрэгжүүлж, нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийг дэмжих, дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлэх, шинэ суурьшлын бүсийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлнэ.



БООМТЫН СЭРГЭЛТИЙН ХҮРЭЭНД

Боомтын сэргэлт, эдийн засгийн өсөлтийг хангах, экспортыг нэмэгдүүлэх зам тээврийн сүлжээг өргөжүүлэх, нутгийн зам хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.



ЭРЧИМ ХҮЧНИЙ СЭРГЭЛТИЙН ХҮРЭЭНД

Цахилгаан, дулааны эрчим хүчний үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлэн, өсөн нэмэгдэж байгаа хэрэгцээг дотоодоос бүрэн хангах нөхцөлийг бүрдүүлнэ.

Дээрх бодлогын хүрээнд дараах зарчмыг баримталж ажиллана. Үүнд:

1. Төсвийн хөрөнгө оруулалтаар эхлүүлсэн төслүүдийг үргэлжлүүлж, хугацаанд нь дуусгах;
2. “Шинэ сэргэлтийн бодлого”, засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан төслүүдийг хэрэгжүүлэх, эх үүсвэрүүдийн уялдааг хангах;
3. Төсвийн хөрөнгө оруулалтыг жигд хуваарилах бус эрэлт, хэрэгцээ, ач холбогдлоор эрэмбэлж төлөвлөх;
4. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем, аргачлалын дагуу төлөвлөсөн болон газрын асуудал шийдэгдсэн, зураг төсөвтэй төслүүдийг тусгах.

Түүнчлэн, “Төсвийн шинэчлэл”-ийн хүрээнд төсвийн хөрөнгө оруулалтын бодлогыг шинэчлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж улсын төсвийн хөрөнгө оруулалтын аргачлалын дагуу боловсруулсан, цахим системд төлөвлөсөн, бэлтгэл ажил бүрэн хангагдсан төслүүдийг төсвийн төсөлд тусгадаг болох, ингэснээр эдийн засгийг идэвхжүүлэхтэй холбоотой нийгмийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, оновчтой, үр ашиг бүхий төслүүдийг хэрэгжүүлнэ.

Цаашлаад урьдчилсан үнэлгээний /pre-screen/ аргачлалыг нэвтрүүлж, хөрөнгө оруулалтын удирдлагын нэгдсэн процесс, тогтолцоог бий болгож хэрэгжүүлнэ. Мөн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж эхэлсэн төслүүдийн үлдэгдэл санхүүжилтийг гүйцэтгэл суурилан, аргачлалын дагуу эрэмбэлсний үндсэн дээр ирэх оны төсөвт тусгах аргачлалыг хэрэгжүүлж ажиллана.

Мөн 2023-2025 онд улсын төсвөөс төлөх “Барих-Шилжүүлэх” концессын төслүүдийн эргэн төлөлт төсөвт томоохон дарамт болох нөхцөл байдал бий болсон байна. Тухайлбал, 2023-2024 онд нийт 703.6 тэрбум төгрөг шаардлагатай болох тооцоо гарсан байна.

2. ГАДААД ЗЭЭЛ, ТУСЛАМЖИЙН АШИГЛАЛТ, БАРИМТЛАХ ЗАРЧМУУД

Монгол Улсын дунд хугацааны гадаад зээл, тусламжийн ашиглалтын төсөөллийг Монгол Улсын хөгжлийн урт, дунд, богино хугацааны бодлого, Засгийн газраас баримталж буй Коронавируст халдвар (КОВИД-19)-т цар тахлын эдийн засагт үзүүлсэн сөрөг нөлөөллийг бууруулах, эдийн засгийн хүндрэлийг даван туулах төсвийн үр ашигтай зарцуулалтын бодлого болон Улсын

Их хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын зорилттой уялдуулан, дараах зарчмыг үндэслэн боловсрууллаа. Үүнд:

1. Зээл, тусламжийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжиж дуусах, төслүүдийн санхүүжилтийг бүрэн олгож, хугацаанд нь үр дүнтэй хэрэгжүүлэх.
2. Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогод туссан, Засгийн газрын баримталж буй бодлоготой нийцэх тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх. Энэ хүрээнд Коронавируст халдвар (КОВИД-19)-т цар тахлын дараах эдийн засгийн салбаруудыг сэргээх, эдийн засгийн өсөлтийг дэмжих тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэн, санхүүжилтийг түлхүү тусгах зарчмыг баримтална.
3. Шинээр хэрэгжүүлэх болон хэлэлцээрийн шатандаа байгаа төслийг “Шинэ сэргэлтийн бодлого”-той уялдуулах. Шинэ төсөл болон хэлэлцээрийн шатандаа байгаа төслийг “Шинэ сэргэлтийн бодлого” болон хөгжлийн бусад бодлого хөтөлбөртэй уялдуулан, тэргүүлэх ач холбогдлоор эрэмбэлэгдсэн эсэхийг нягтлан, ДНБ-д эзлэх өрийн хязгаарт нийцүүлэн хэрэгжүүлэх чиглэл баримтална. Энэ хүрээнд гэрээ, хэлэлцээрийн шатанд байгаа шинэ төсөл, хөтөлбөрийг 10 сая төгрөгөөр тусган хэлэлцээр хийх боломжийг олгох, гэрээ нь байгуулагдаж, ажил эхэлсний дараа гүйцэтгэлээр нь нэмэгдүүлэн санхүүжүүлэх боломжтой байхаар төлөвлөж байна.

Шилжих төслийн хувьд эдийн засгийн сэргэлтийг дэмжих төсөл, арга хэмжээг нэн тэргүүнд санхүүжүүлэх. Эдийн засгийн тогтвортой өсөлт, сэргэлтийг дэмжих бодлогын хүрээнд хилийн боомт, зам тээвэр, эрчим хүч, усан хангамж, экспорт, үйлдвэрлэлийг дэмжсэн төслүүдийг гүйцэтгэл, үр дүнг харгалзан нэн тэргүүнд санхүүжүүлэх, мөн цар тахлын эдийн засагт үзүүлсэн эх сөрөг нөлөөллийг бууруулах, Засгийн газраас баримталж буй эдийн засгийн хүндрэлийг даван туулах төсвийн үр ашигтай зарцуулалтын бодлого чиглэлтэй нийцүүлэн төслийн үйл ажиллагааг хэмнэлттэй, оновчтой зохион байгуулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

■ МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХҮҮГ 1 НЭГЖ ХУВИАР НЭМЭГДҮҮЛСЭН НЬ ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛД НИЙЦТЭЙ ШИЙДВЭР БОЛСОН ГЭЖ ЭДИЙН ЗАСАГЧИД ДҮГНЭЖ БАЙНА

Мөнгөний бодлогын хорооны II улирлын хуралдаанаар гаргасан шийдвэрийн талаар эдийн засагчид дараах байр суурийг илэрхийллээ.



С.ДЭМБЭРЭЛ
Эдийн засгийн
сургалт, судалгааны
хүрээлэнгийн захирал

Эдийн засгийн өсөлт, гарцын зөрүү сөрөг хэвээр, стагфляцын шинж тэмдгүүд арилаагүй хэвээр тул бодлогын хүүг бага зэрэг нэмэх нь оновчтой. 2010-2019 оны дундаж инфляц 8 хувь орчимд аргамжигдсан өөрөөр хэлбэл тогтвортой чанар нь өмнөх 10 жилээс нэмэгдсэн нь мөнгөний бодлогын үр дүн гэж үзэж болно. Харин төсвийн алдагдал, төсвийн давамгайлал нь инфляцыг нэмэгдүүлэх нэг гол шалтгаан. Үүнд УИХ зохистой түвшинд анхаарахгүй байгаа нь мөнгөний бодлогын үр нөлөөг бууруулж ирсэн, цаашид ч бууруулах төлөвтэй байна. Мөнгөний нийлүүлэлт буюу нэрлэсэн ба бодит дотоодын нийт бүтээгдэхүүн, суурь мөнгө, мөнгөний эргэц, үржүүлэгч хоорондын хамаарлыг Монголбанк илүү сайн анхаарч, цаашид тохируулга хийх нь улам бүр чухал болж байна. Инфляц бол хаана ч хэзээ ч мөнгөний үзэгдэл байдаг гэдэг мөнгөний тооны онол өнөө үед дахин хүчээ авч байна гэдгийг харгалзан тохируулга хий гэсэн үг. Гадаад өрийн дарамт инфляцыг нэмэгдүүлж буй өсөн нэмэгдэж буй нэг аюул гэдгийг УИХ Засгийн газар онцгой анхаарах цаг ирж байна. Мөн өрхийн эдийн засаг дээр инфляцын дарамт улам бүр нэмэгдэж буй тул татвар нийгмийн даатгалын шимтгэл гэх мэт бодлогын тохируулга хийх нь Засгийн газрын бодлогоор л хийгдэх ёстой. Өөрөөр хэлбэл, мөнгөний бодлого өөрийн хуулийн болон институцийн хязгаарлалтуудтай гэдгийг ойлгох хэрэгтэй. Эцэст нь ач холбогдлын хувьд эхэнд нь байх ёстой нэг асуудал бол төв банкны бие даасан байдал руу халдах нь инфляцыг онилох зорилтыг нь саармагжуулдаг олон улсын гашуун туршлагыг Монгол Улс давтаж байна. Үүнийг зогсоох хэрэгтэй. Жо Байден саяхан “Инфляцтай тэмцэх миний төлөвлөгөө” гэж гаргасан бөгөөд хамгийн эхэнд нь Холбооны нөөцийн сангийн бие даасан байдлыг чухалчилсан байна. Үүнийг онцгой анхаарах хэрэгтэй.



Д.ОЮУНБАДАМ
Нээлттэй нийгэм
форумын эдийн
засгийн асуудал
хариуцсан менежер

“Инфляц 15 хувьд хүрсэнээс гадна цаашид улам өсөх хандлага ажиглагдаж байгаа тул мөнгөний бодлогын хүүг 1 нэгж хувиар нэмэгдүүлж, 10 хувьд хүргэснийг зөв арга хэмжээ гэж харж байна. Дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнийн өсөлт, тээвэр, логиستيкийн саатал, тээврийн зардлын өсөлт зэргээс шалтгаалсан шатахуун, хүнс болон импортын барааны үнийн өсөлт инфляцын дийлэнх хэсгийг бүрдүүлж байгаа статистик мэдээлэл гарсан. Гэсэн хэдий ч инфляцын өсөлтийг сааруулахад хувь нэмэр оруулах үүднээс мөнгөний хумих бодлогыг хэрэгжүүлэх нь зүйтэй. Инфляцыг тогтворжуулахын тулд Монголбанкны зүгээс мөнгөний бодлогын арга хэмжээ авахаас гадна Засгийн газрын зүгээс мөн төсвийн зарлагын асуудалд анхаарах хэрэгтэй. Жишээлбэл, эдийн засгийн хүндрэлтэй үед тэвчиж болох төсвийн хөрөнгө оруулалтын зарим төсөл, засварын ажлыг хойшлуулж, хүнсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн төслүүдэд хөнгөлөлттэй зээл олгох замаар илүүтэй дэмжих зэрэг арга хэмжээ авах нь зүйтэй юм.



Ж.ДЭЛГЭРСАЙХАН
СЭЗИС-ийн профессор,
эдийн засагч

Мөнгөний бодлогын хүүг нэг нэгж хувиар нэмэгдүүлж бусад бодлогын нэмэлт тохиргоо хийгээгүй нь өнөөдрийн нөхцөл байдалд нийцтэй шийдвэр. Өнөөгийн хүнд нөхцөл байдал нь макро бодлогын амаргүй сонголтыг бидэнд тулгаж байна. Иймээс мөнгөний бодлогын хувьд харьцангуй бага хүүгийн өсөлтийг сонгосон нь зөв байх боломжтой.

Гэхдээ энэхүү үнийн өсөлтийг дан ганц мөнгөний бодлогоор хянах, удирдахыг хүчтэй оролдох нь эдийн засгийг эрсдэлд оруулах нөлөөтэй юм. Эдийн засаг хоёр жилийн хөл хорио, бусад хязгаарлагдмал нөхцөл байдлын дараа эргэн сэргэх шинж тэмдэг мэдрэгдэж эхэлж байгаа үед мөнгөний нийлүүлэлтийг огцом бууруулах нь ирээдүйн эрсдэлийг нэмэгдүүлэх хандлагатай юм. Нөгөө талаас үнийн өсөлтийн үндсэн шалтгаан нь нийлүүлэлтийн хомсдол, тээврийн үнийн өсөлт, тээврийн хугацааны асуудал. Үүн дээр нэмээд валютын ханшаар дамжсан импортын үнийн өсөлт нөлөөлж байна. Үүний эсрэг тэмцэх үндсэн арга нь мөнгөний захаас илүү нийлүүлэлтийн доголдлыг арилгах, экспортыг нэмэгдүүлэх явдал. Харамсалтай нь бид үүний эсрэг дорвитой зүйл хийх боломж хязгаарлагдмал байгаа нь эдийн засгийн нөхцөл байдлыг хүндрүүлж байна. Иймд мөнгөний хэт хумих бодлого явуулах нь энэ эдийн засгийн хүнд нөхцөл байдлыг даамжруулж болзошгүй юм. Миний хувьд өнөөгийн Монгол Улсын нөхцөл байдал стагфляцын шинжтэй байна гэж үзэж байна. Эдийн засгийн уналт, үнийн өсөлт нь үүнийг тодорхойлж байна. Энэ нь удаан үргэлжилсэн тохиолдолд эдийн засагт хүчтэй сөрөг нөлөөллийг бий болгоно. Ялангуяа орлого багатай, ядуу иргэдийн амжиргааг доройтуулна. Харин энэхүү нөхцөл байдлыг үгүйсгэх мэт харагдаж байгаа хөдөлмөрийн зах зээлийн бага зэрэг сэргэлт, иргэдийн хэрэглээнд хууртах хэрэггүй. Энэ нь эрүүл мэндийн шалтгаантай энэхүү онцгой хямралын дараах жам ёсны үзэгдэл гэж би хувьдаа үзэж байна. Учир нь 2 жил хөл хорио, хязгаарлагдмал нөхцөлд байсан иргэд, ААН-үүд хөдөлгөөнд орох нь тодорхой. Энэ нь зарим үзүүлэлтийг эерэг харагдуулж байна. Гэтэл энэ хөдөлгөөнд орсон байдлыг дэмжих суурь нөхцөл бүрдээгүй гэдгийг санах хэрэгтэй” гэсэн юм.

**Н.ЭНХБАЯР**

Эдийн засагч,
"стратегийн судалгааны
хүрээлэн"-ийн эдийн
засаг, аюулгүй байдлын
судалгааны төвийн
дарга

Монголбанкнаас бодлогын хүүгээ нэмэгдүүлэхээр шийдвэрлэсэн нь өнөөгийн бодит нөхцөл, цаашдын учирч болох эрсдэлтэй нийцсэн зөв шийдвэр болсон. Хилийн боомтууд дээр үүсч байгаа экспортын саатал, импортын тасалдлыг зогсоож, боомтуудын үйл ажиллагааг хэвийн болгох арга хэмжээг Засгийн газраас авч хэрэгжүүлсэний дараа нийлүүлэлтийн тасалдал арилж, инфляц тогтворжих боломжтой гэж үзэж байна. Бензин шатахуун (АИ92)-ы үнийн өсөлт ирэх гуравдугаар улиралд тохиох нь тодорхой байна.

2023 онд хөгжиж буй эдийн засагтай орнуудын 40%-д нь нэг хүнд ногдох бодит орлого нь COVID-19 цар тахлаас өмнөх түшингээс доогуур хэвээр байх болно. Мөн нэлээн хэдэн улс орны хувьд эдийн засгийн хямралаас сэргийлэхэд мөн адил хүнд байх болно. Байгалийн хийн нийлүүлэлтийн хязгаарлагдмал байдал нь ядуу буурай орнуудад газар тариаланд ашиглагдах бордоо болон тог цахилгааны хомсдол гэх мэт хүндрэлүүдийг бий болгож байгаа тул дэлхийн хэмжээнд үйлдвэрлэлийн томоохон өсөлтийг бий болгохыг зарлах нь инфляц дээр дарамт учруулахгүйгээр эдийн засгийн өсөлтийг дэмжихэд зайлшгүй шаардлага болж байна.

Инфляц дунджаас дээгүүр байх болон эдийн засгийн өсөлт дунджаас доогуур байх нь дараачийн хэдэн жилийн турш үргэлжлэх аюултай байгаа ба 1970-аад оноос хойш ажиглагдаагүй үзэгдэл юм. 2021-2024 оны хооронд дэлхийн эдийн засгийн өсөлт 2.7 пунктээр удаашрах төлөвтэй байгаа нь 1976-1979 оныхоос хоёр дахин илүү удааширч байгаа нь энэ юм. Дэлхийн ихэнх улс оронд хөрөнгө оруулалт сул байгаагаас шалтгаалан эдийн засгийн өсөлт ойрын хэдэн жилийн турш саарах төлөвтэй байна. Мөн олон улс оронд инфляц хэдэн арван арван жилийн туршид хүрч байгаагүй дээд түвшинд хүрсэн бөгөөд үүнтэй зэрэгцээд нийлүүлэлт ч мөн адил удаашралтай байхаар байна. Энэ нь үнийн өсөлт таамаглаж байснаас удаан үргэлжлэх эрсдэлийг бий болгож байна.

МОНГОЛБАНКНЫ ЭРДЭНЭСИЙН САНГААС

МОНГОЛ АРДЫН ХУВЬСГАЛТ ЦЭРГИЙН ГЕНЕРАЛ СЭЛЭМ

Он: 1945

Жин: 1556 гр, 97х3.8см



Ган төмрийг давтаж матигар хэлбэр оруулан дээр нь “МАХЦ-ийн генерал” хэмээх үгийг алтаар шарж хийсэн сэлэм. Бариулыг алтаар тоноглож хоёр талд нь бадмаараг эрдэнээр хийсэн таван хошуу шигтгэж, бариулын хоёр талын угт 1940 оны төрийн сүлдийг байрлуулан сэлэмний балтыг /гар хамгаалагч/ тойруулан бадмаараг чулуу шигтгэн чимэглэжээ.

Сэлэмний хуйг нимгэн гангаар үйлдэж, зүүсгэл тээг, төгсгөл хэсгийг түмэн наст болон хатан сүйх, үүлэн хээгээр чимэглэн алтаар шарж, хээ бүрийн дээр үнэт эрдэнийн чулууг шигтгэсэн байна.



МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХОРООНЫ II УЛИРЛЫН ШИЙДВЭР ТАНИЛЦУУЛАХ ХЭВЛЭЛИЙН БАГА ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Мөнгөний бодлогын хороо 2022 оны 6 дугаар сарын 22-ны өдөр хуралдаж, мөн өдөр хэвлэлийн бага хурал зарлан шийдвэрээ танилцууллаа. Хэвлэлийн бага хуралд Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн, Ерөнхий эдийн засагч Д.Ган-Очир, Мөнгөний бодлогын газрын захирал Б.Баярдаваа нар оролцож сэтгүүлчдийн сонихирсон асуултад хариулт өглөө. Тус хурлын тэмдэглэлийг бүрэн эхээр нь толилуулж байна.

Ийгл ТВ: Тавдугаар сард ОУВС-ийн ажлын хэсэг Монголд ажиллаж, тайлан гаргахдаа одоогийн нөхцөл байдалд мөнгөний бодлогын төлөвийг дахин хатууруулах шаардлагагүй гэж дүгнэсэн. Гэхдээ Монголбанк 1 нэгж хувиар нэмэгдүүлэх шийдвэр гаргалаа. Мөнгөний бодлогын төлөвийн өөрчлөлтийг төсвийн бодлого дэмжихгүй байх тохиолдолд үр дүн багатай гэж мөн дүгнэсэн байсан. Тэгэхээр одоогийн мөнгөний бодлогын өөрчлөлтийг төсвийн бодлого дэмжихгүй байх тохиолдолд үр дүнг та бүхэн хэрхэн харж байна вэ?

Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн:

ОУВС-ийн ажлын хэсэг Монголд ажиллаад, гаргасан дүгнэлтдээ Монголбанк 1 дүгээр улиралд бодлогын хүүгээ 2.5 нэгж хувиар буюу огцом нэмэгдүүлсэн учраас үр дүнг нь ажиглах хэрэгтэй гэсэн байдлаар зөвлөмж хүргүүлсэн. Тийм учраас мөнгөний бодлогын хорооны хурлын үеэр энэ

асуудлыг нэлээд ярилцсан. Бодлогын хүүг 9 хувьд хүргэж өсгөсөн шийдвэрээ хэвээр хадгалж, дахиад ажиглах уу гэдэг асуудлыг нэлээд олон талаас нь хэлэлцсэн. Гэхдээ тавдугаар сараас хойш олон улсын болон манай улсын дотоодын нөхцөл байдал нэлээд эрчимтэй өөрчлөгдөж байна. Нэгдүгээр улиралд шийдвэр гаргаж байх үед төв банкууд бодлогын хүүгээ өсгөх үү, үгүй юу гэх асуудлыг ярьж байсан. Нөгөөтэйгүүр гарч байгаа шийдвэрүүд өмнө нь ярьж байснаасаа өөрөөр гарч байна. Хамгийн сүүлд Холбооны нөөцийн сангаас бодлогын хүүгээ 0.5 нэгж хувиар өсгөх байсан ч 0.75 нэгж хувиар өсгөх шийдвэр гаргасан. Үүнтэй зэрэгцээд удахгүй дараагийн хурлаа хийж, дахин 0.75 нэгж хувиар өсгөх асуудлыг ярьж байгаа. Ийм маягаар огцом шийдвэрүүд гарч байгаа учраас гадаад нөхцөл байдлын хувьд эрсдэл өндөр байна гэж харж байна. Энэ утгаараа Мөнгөний бодлогын хороо шийдвэр гаргахдаа ОУВС, Дэлхийн банк, бусад байгууллагуудын зөвлөмж байгаа хэдий

ч нөхцөл байдал хурдтай өөрчлөгдөж байгаа учраас хариу арга хэмжээг урьдчилан авах шаардлагатай гэж үзсэн. Энэ бол хамтын шийдвэр. Хорооны гишүүдийн хувьд олон янзын байр суурьтай байсан. Зарим нь ОУВС-ийн зөвлөмжийн дагуу харзнавал яасан юм бэ гэх байр суурь илэрхийлсэн. Бас зарим нь бүр илүү хувиар өсгөх тухай саналаа ч илэрхийлж байсан.

Инфляцын хувьд иргэдийн хүлээлт нэлээд өндөр байгаа. Төв банкны зүгээс зорилтот түвшинд хүрэх хугацаагаа 2 улирлаар хойшлуулж харж байгаа юм байна. Гэхдээ иргэд оны эцэст инфляцыг бараг 20 хувьд хүрнэ гэж хүлээж байх шиг байна. Та бүхэн ямар хүлээлттэй байна вэ?

Олон улсын хурцадмал байдал, хүнсний үнийн өсөлт зэргээс үүдэлтэйгээр түүхий эдийн үнэ өндөр байсаар байна. Ялангуяа бензин, шатахуун, тослох материалын үнэ маш өндөр түвшинд хүрсэн. Энэ байдал бүх улсад нөлөөлж байгаа. Монгол Улсад ч ялгаагүй. Үүний дам нөлөө гэж мэдээж гарч ирнэ. Өөрөөр хэлбэл, бензиний үнийн өсөлтөөр дамжаад бусад бүтээгдэхүүний үнэд ямар нөлөө үзүүлэх вэ гэдэг асуудал нь олон нийтийн дунд инфляц 20 хувьд хүрнэ гэх төсөөлөлд хүргэж байхыг үгүйсгэхгүй. Бидний хувьд энэ оны инфляц өнөөгийн түвшнөөс нэг их огцом өсөхгүй гэсэн хүлээлттэй байна. УИХ-аас гол нэрийн бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах, нөөц бүрдүүлэх хууль гаргасан. Тийм учраас инфляц тэгж их өндрөөр өсөхгүй гэж тооцоолж байна.

Холбооны нөөцийн банк бодлогын хүүгээ нэмэгдүүлсэн. Энэ нь манай улсын валютын ханшид хэрхэн нөлөөлөх вэ?

Төгрөгийн ханш оны эхнээс 9.5 хувиар сулраад байна. Онолын хувьд манай улсад байгаа инфляц болон худалдааны түнш орнуудын инфляцын зөрүүгээр ханшийн тохиргоо хийгдэж байх ёстой. Манай улсын инфляц 15 хувьтай байна. АНУ-ын инфляц 8 хувьтай байгаа учраас ханшийн зөрүүний тохиргоо 7 хувийн орчимд байх учиртай. Энэ бол сурах бичигт заасан онол. Тэгэхээр онолын дагуу бол төгрөгийн ханш оны эхнээс 9.5 хувиар суларсан учраас хангалттай тохиргоо хийгдсэн гэж

харж болохоор. Гэхдээ амьдрал дээр мэдээж бүх зүйл онолын дагуу явахгүй. Монгол Улсын гадаад худалдааны тэнцэл, төлбөрийн тэнцэл буюу Монгол Улсад орж ирж байгаа болон гарч буй валютын зөрүү маань -1 тэрбум ам.долларт хүрсэн байна. Энэ нь ханш дээр тохиргоо хийгдээд явах юм байна гэдэг зүйл харагдаж байгаа.

Төсвийн тодотголын хувьд та ямар байр суурь илэрхийлэх вэ?

Төсвийн тодотголоор өнөөдөр төсвийн зардал 18 их наяд, орлого 16 их наяд байна. Тодотголоор 200 тэрбум төгрөгийн хэмжээнд тодотгосон учраас төсөв тэлэлттэй байх юм байна. Төсөв тэлэлттэй байгаа үед мөнгөний бодлогод хатуурахаас өөр орон зай байхгүй. Ингэж байж л нийцтэй байдал бий болно.

Блүүмбэрг ТВ: ОУВС эдийн засгийн өсөлтийг 1 хувьд хүрнэ гэж тооцсон. Мөн стагфляцын эрсдэл байгаа талаар анхааруулсан. Тэгэхээр Монголбанк бодлогын шийдвэрийг гаргахдаа стагфляцын эрсдэлийг хэрхэн харж, дүгнэсэн бэ?

ОУВС Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг 1 хувь гэж төсөөлсөн. Монголбанк 2.4 хувь гэж харж байгаа. Энэ нь өмнөх төсөөллөөс өөрчлөгдөөгүй. Яагаад гэвэл Монгол Улсын эдийн засаг 1 дүгээр улиралд 3.8 хувиар агшсаныг та бүхэн мэдэж байгаа. Үүнд уул уурхайн салбарын агшилт нэлээд томоохон хувийг бүрдүүлж байна. Харин уул уурхайн бус салбар өсөлттэй гарсан. Уул уурхайн салбарын гол экспорт бол нүүрс. Монгол Улс 2019 онд 36 сая тонн нүүрс олборлож, экспортолж байсан. Энэ онд 15 сая тонныг л экспортолж, бараг хоёр дахин буурсан. Хэрвээ нүүрсний экспорт сэргэвэл, уул уурхайн салбарын уналт зогсоно. Уул уурхайн салбарт өсдөггүй юм гэхэд уналтгүй байхад уул уурхайн бус эдийн засгийн сэргэлтийг бий болгоно гэж харж байгаа. Нэгдүгээр улирал болон тавдугаар сарын бүх тоо, материал дээрээ шинжилгээ хийгээд үзэхээр, худалдаа, үйлчилгээ, боловсруулах болон ХАА-н салбар дээр өсөлт гараад эхэлчихсэн. Энэ өсөлт цаашдаа хэвээр үргэлжилнэ. Тэгэхээр уул уурхайн салбарынхаа уналтыг зогсоогоод 0 болгоход, эдийн засгийн өсөлт 2.4 хувьтай байна гэсэн тооцоолол

юм. БНХАУ-ын тэг ковид бодлоготой холбоотойгоор манай уул уурхайн салбар бүрэн хүчин чадлаараа ажиллаж чадахгүй байгаа. Гэхдээ сүүлийн үеийн мэдээг харвал, Шанхай хотод бараг хоёр сар үргэлжилсэн хатуу хөл хорио цуцлагдлаа. Шанхайд сүүлийн хоёр долоо хоног ковидын тохиолдол бүртгэгдсэнгүй. Хятадын эдийн засаг бас сэргэж байгаа нь манай экспортын эрэлтийг нэмэгдүүлэхээр байна. Бид хил, боомтуудаа нээж чадвал уул уурхай дээрээ сэргэлт авчраад, өсөлт бий болгох бололцоотой юм.

Нөгөө талаас уул уурхайн салбар бол техникээр ажилладаг, ажиллах хүчний оролцоо багатай. Харин ажиллах хүчний оролцоо ихтэй худалдаа, үйлчилгээ, хөдөө аж ахуйн салбарт ахиц гарч байгаа нь хэрэглээг дэмжиж байгаа. Тэгэхээр хэрэглээгээр дамжаад эдийн засаг сэргэх боломжтой гэж үзэж байна.

Инфляц зорилтот түвшний орчимд хүрэх хугацааг хоёр улирлаар хойшлуулсан байна. Тэгэхээр цаашид мөнгөний бодлогын төлөвийг хатууруулна гэсэн үг үү?

Төв банкны үндсэн зорилго нь төгрөгийн тогтвортой байдал буюу инфляцыг л аль болох нам дор түвшинд хадгалахыг зорьдог. Гэхдээ өнөөгийн нөхцөл байдал нь шууд төв банкны бодлогоор удирдагдахааргүй байна. Монгол Улсын хэрэглээний сагсны 370 гаруй бараа, бүтээгдэхүүний бараг 50 хувь нь импортын бүтээгдэхүүн байна. Манай худалдааны түнш орнуудын инфляц өссөөр байна. БНСУ-д гэхэд инфляц 7 хувьд хүрч, сүүлийн 20 жилд байгаагүй өндөр түвшинд хүрсэн. Тэгэхээр жишээлбэл, БНСУ-ын хувьд авч үзвэл манай улс тус улсаас бараа, бүтээгдэхүүн импортлоход өндөр давхар инфляцыг нь авах буюу үүрч байна. Тиймээс инфляцтай импорт нь дотоодод бараа бүтээгдэхүүний үнэ өсөх шууд шууд шалтгаан болж байгаа юм. Хэдийгээр улаан лооль, өргөст хэмх, байцай, луувангийн хувьд нэг хэсгийг нь импортоор, нэг хэсгийг нь дотооддоо ургуулдаг ч импортынх нь үнэ өсчихөөр, дотооддоо үйлдвэрлэж байгаагийнх нь үнэ дагаад өсч байгаа тал бий. Энэ утгаараа инфляц удаан үргэлжлэх шинж тэмдэг бий. Нөгөө талаар Украин, Оросын

хурцадмал нөхцөл байдалтай холбоотойгоор нефтийн үнэ нэлээд өндөр байна. Үүний дам нөлөө ч бас удаан хугацаанд үргэлжилнэ. Бусад улсуудын төв банкуудын хэлж байгааг давтаж хэлэхэд, энэ нөхцөл байдал жилийн дараа л тогтворжино гэгцгээж байна. Тийм учраас бид ч бас инфляц импортлох байдал тодорхой хугацааны дараа тогтворжино гэсэн төсөөлөлтэй байна.

Бодлогын хүүг өсгөснөөр инфляц, валютын ханш, санхүүгийн зах зээлд хамгийн түрүүнд ямар үр дүн гарна гэж харж байна вэ?

МБГ-ын захирал Б.Баярдаваа:

Энэ удаагийн шийдвэр нь өмнөх бодлогын шийдвэрүүдийн үргэлжлэл. Тэгэхээр мөнгөний бодлогын хуримтлагдсан нөлөөлөл томорч байна гэсэн үг. Нэгдүгээр сард бодлогын хүүг 0.5 нэгж хувиар нэмэгдүүлэхтэй зэрэгцээд төгрөгийн заавал байлгах нөөцийг 2 нэгж хувиар чангаруулсан. Гуравдугаар сард бодлогын хүүг 2.5 нэгж хувиар өсгөсөн. Ингэснээр бодлогын хүү 6 хувиас 3 нэгж хувиар нэмэгдсэн. Түүнчлэн заавал байлгах нөөцийн хэмжээ 2 нэгж хувиар нэмэгдсэний дараа өнөөдрийн шийдвэр гарч байна гэсэн үг. Үүнтэй холбогдуулаад хамгийн эхний гарч ирэх үр нөлөө нь хадгаламжийн хүү нэмэгдэнэ. Өмнөх гарсан шийдвэрүүдтэй холбоотойгоор өсч байсан хадгаламжийн хүү үргэлжлэн нэмэгдэнэ гэсэн үг. Энэ нь төгрөгийн өгөөжид нөлөөлнө. Хадгаламжийн хүүг дагаад зээлийн хүү өснө. Ийм нөлөө хамгийн эхэнд гарч ирнэ. Энэ нь хөрөнгө оруулалт, хэрэглээ, эдийн засгийн өсөлтөд давхар нөлөө үзүүлнэ. Гэхдээ дунд хугацаандаа инфляцыг ужигруулахгүйн тулд өнөөдрийн бодлогын шийдвэрийг гаргаж байгаа. Тийм болгоомжлол байгаа учраас шалтгаанаас нь үл хамааран бодлогын арга хэмжээг авч байгаа юм. Инфляцыг ужигруулахгүйгээр аль болох богино хугацаанд хяналтдаа авснаар дунд хугацааны эрсдэлийг бууруулж, макро эдийн засгийн тогтвортой орчныг аль болох эрт бүрдүүлнэ гэсэн үг. Гэхдээ үүнийг хийхээсээ өмнө бид эдийн засаг дөнгөж сэргэж байгаа өнөөгийн нөхцөл байдлыг харгалзаж үзэх ёстой. Хэт том алхаж болохгүй. Тэгэхээр энэ балансыг харж, бид шийдвэр гаргаж

байна. Гадаад орчноос орж ирж байгаа инфляцын талаар Монголбанкны Ерөнхийлөгч тодорхой тайлбарласан. Нөгөө талаас улс орнууд бодлогын хүүгээ огцом нэмэгдүүлж байгаа энэ үед Монголбанк тэдгээртэй дүйцүүлж шийдвэр гаргахаас өөр аргагүй нөхцөл байдалд хүрч байна. Монголбанкны хувьд Холбооны нөөцийн сангийн бодлогын хүү 0.75 нэгж хувиар нэмэгдэхээс өмнө 3 нэгж хувиар бодлогын хүүгээ нэмэгдүүлсэн байсан. Холбооны нөөцийн банк сая бодлогын хүүгээ 0.75 хувиар нэмэгдүүлсэн, ирэх долоодугаар сард дахин 0.75 нэгж хувиар өсгөнө гэж байгаа. Үүнтэй зэрэгцээд Монголбанк бодлогын хүүгээ 1 нэгж хувиар өсгөж байна. Тэгэхээр цаашид гадаад хүү бидний анхаарч байх ёстой зүйл болж байгаа юм. Нөгөө талаас гадаад хүүний өөрчлөлт дэлхийн эдийн засгийн идэвхжилд хэрхэн нөлөөлөх, энэ нь экспортын гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнэд хэрхэн нөлөөлөх вэ гэдгийг анхааралтай ажиглаж, судалж байна. Дараагийн нэг зүйл нь дэлхийн улс орнууд, төв банкууд 2023 оны төгсгөл рүү инфляц зорилтот түвшинд хүрнэ гэсэн хүлээлттэй байгаа. Гурван улирлын өмнө гэхэд бид 2022 оны төгсгөлд инфляц зорилтот түвшинд хүрнэ гэх хүлээлттэй байсан. Орос Украины хоорон дахь асуудал үүссэнээс хойш энэ төсөөлөл бүтэн жилээр хойшилсон. Тэгэхээр энэ нөхцөл байдлыг бид гадаад инфляц, импортын үнэ гэдэг зүйл дээр суурь нөхцөл байдал болгож авч үзсэн. Нэг ёсондоо төв банкууд ингэж үнэлж байгаа учраас үүний нөлөөлөл Монголын эдийн засагт орж ирнэ гэсэн байр сууринаас хандаж байгаа юм.

Itoim.mn Олон улсын нөхцөл байдалтай уялдуулан дараагийн арга хэмжээг авна гэж байна. Тэгэхээр олон улсын нөхцөл байдал сайжирвал яах вэ, эсвэл бүр дордвол яах вэ гэдэг бодлогын хувилбаруудын талаар ямар төсөөлөлтэй байна вэ?

Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн:

Бидний эхний алхам бол их том байсан. 2.5 нэгж хувиар өсгөсөн. Бодлогын хүү 9 хувьд хүрснээр зээл, хадгаламжийн хүү өсч эхэлсэн. Ковидын дараа эдийн засаг дөнгөж л сэргэж эхэлж байна. Аялал жуулчлал, нийтийн хоол, бусад үйлчилгээний салбар, хөдөө

аж ахуйн салбарт сэргэлт гарч эхэлж байгаа. Ингээд сэргэж байтал гэнэт санхүүгийн төлөв нь хатуураад, зээл үнэтэй болоод, олдоц нь багасвал сэргэлт зогсох, саармагжих үр дагавар гарч ирнэ. Тэр утгаараа бодлогын хүүг өсгөхөд төвөгтэй. Гэхдээ олон улсын хурцадмал байдлаас болоод хүнсний бүтээгдэхүүн, нефть, шатахууны үнэ бүх улсад өсчихсөн. Энэ нөлөө Монгол Улсад орж ирэх нь ойлгомжтой учраас бид бодлогын хүүгээ чангаруулж, урьдчилсан арга хэмжээ авч байгаа юм. Нөгөө талдаа эдийн засгийн өсөлтөө их болгоомжтой хандаж байна гэсэн үг. Хэрвээ эдийн засгийн өсөлтөө бодвол бид бодлогын хүүг өсгөхгүй байх хэрэгтэй байна шүү дээ. Гэтэл эдийн засаг сэргэхтэй зэрэгцээд стагфляцын асуудал сая хөндөгдсөн. Эдийн засаг сэргэхгүй бол инфляц өсдөг л үзэгдэл. Хэрвээ яг тоогоо харвал нэгдүгээр улирлын тоо -3.8 болон унаж, инфляц 15 хувьд хүрсэн. Энэ тоог харвал яг л стагфляц болчихсон юм шиг харагдах боловч өөр нэг дүр зургийг харвал ажил эрхлэлт 10 хувиар нэмэгдсэн байгаа. Өрхийн орлого нэмэгдэж, түүгээр дамжсан хэрэглээ өссөн учраас арай өөр дүр зураг юм. Тэр утгаараа бид олон улсын нөхцөл байдалтай уялдуулан, мөнгөний бодлогын төлөвийг хатууруулах арга хэмжээгээ үргэлжлүүлж байгаа. Гэхдээ бүр том хэмжээгээр буюу өмнөх шигээ 2.5 нэгж хувиар өсгөхгүй гэж үзсэн. Хэрвээ гадаад худалдаа сэргээд, тэр нь төлбөрийн тэнцлийн алдагдлыг бууруулаад эхэлбэл, бид бодлогын хүүгээ бууруулах боломж нь нээлттэй. Гэхдээ өнөөдөр бид яг тэгж чадна, ийм үр дүн гаргаж чадна гэж хэлэх боломжгүй учраас болгоомжтой байх хэрэгтэй л гэсэн үг. Тавдугаар сарын байдлаар манай гадаад худалдааны тэнцэл ашигтай байсан. Оны эхний гурван сард алдагдалтай байсан ч дөрөв, тавдугаар сард ашигтай гарсан. Үүн дээр нэмээд бидний хүсч байгааачлан нүүрсний экспорт маань сэргэчихвэл байдал илүү тогтворжих боломжтой гэж харж байгаа. Үүнийг зөвхөн Монголбанк ч биш, олон улсын байгууллагууд, рейтингийн байгууллагууд ч онцолж байгаа.

Валютын нөөц яг одоогоор хэд байна вэ?

Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн:

Орос, Украины дайны нөхцөл байдалтай

холбоотойгоор нефтийн бүтээгдэхүүний үнэ эрс нэмэгдсэн. Бидний авч байгаа нефтийн бүтээгдэхүүний хэмжээ хэвээрээ байгаа ч төлдөг мөнгө маань нэмэгдсэн. Энэ утгаараа валютын нөөц дээр тодорхой дарамтыг бий болгож байна. Өнөөдрийн байдлаар Монгол Улсын валютын нөөц 3 тэрбум ам.доллартай тэнцэж байна. Энэ нь 5.8-6 сарын импортын хэрэгцээг хангах түвшин юм. Экспорт сэргэсэн тохиолдолд нөөц нэмэгдэх боломжтой.

Ийгл ТВ: Эдийн засгийн өсөлтийн төсөөллийг бууруулах болов уу гэсэн хүлээлттэй байсан. Гэвч өсөлтөө хэвээр хадгалсан байна. Өсөлтийг хангах аж ахуйн нэгжүүдийн нөхцөл байдал хүнд байна. Дээр нь бодлогын хүүг нэмэгдүүлчихлээ. Түүнчлэн банкуудын хувьд банкны активын чанарын үнэлгээ хийж байгаагаар холбоотойгоор банкууд зээл олгохгүй байна гэх асуудал яригдаж байна. Тэгэхээр активын чанарын үнэлгээ хэзээ дуусах вэ, банкуудын зээл олголт хэзээ хэвийн болох вэ, бодлогын хүүг өсгөсө шийдвэр зээлийн олголтод хэрхэн нөлөөлөх вэ?

Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн:

Банкийг хувьцаат компани болгох, хөрөнгийн биржээр дамжуулж хувьцааг нь арилжаалах арга хэмжээ 2021 оны нэгдүгээр сард эхэлсэн. 2021 оны нэгдүгээр сард Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг баталснаар энэ процесс эхэлсэн. Үүний дагуу бүх бэлтгэл ажлууд хийгдсэн. 2021 оны эхэнд бид Банкны тухай хуулийг баталж, 2022 оны долоодугаар сарын 1 гэхэд банкууд IPO хийнэ гэдэг асуудлыг ярьж байх үед одоогийн үүссэн нөхцөл байдлыг таамаглах аргагүй байсан. Тийм учраас нэгэнт хууль гарсан учраас хуулийн дагуу л ажиллаж ирсэн. Хоёрдугаар сараас эхлээд олон улсын хурцадмал байдал бий болчихлоо. Энэ бүх нөхцөл байдал яг зэрэгцээд байна. Олон улсын байгууллагын зүгээс банкны системд AQR буюу активын чанарын үнэлгээ хийх ёстой гэсэн. Энэ утгаараа Монголбанк активын чанарын үнэлгээг хийгээд явж байна.

Олон улсын нэр хүнд бүхий аудитын компаниудын дунд нээлттэй тендер шалгаруулж, Казахстаны PwC компани шалгарсан. Одоо таван банканд активын чанарын үнэлгээг хийж байна. Бидэнд долоодугаар сард багтаж активын чанарын үнэлгээний үр дүн танилцуулагдана. Өмнө нь 2017 онд хийхдээ Европын төв банкны аргачлалаар үнэлж байсан. Энэ удаад Монголбанкны буюу хяналт шалгалтын аргачлалаар үнэлгээг хийж байна. IPO AQR хоёр нэг нь өмнө нь, нөгөө нь хойно хийгдэх ёстой гэсэн ойлголт байхгүй. Өнөөдрийн байдлаар хоёр банк IPO гаргахаар СЗХ-нд хүсэлтээ өгсөн. СЗХ зөвшөөрлөө өгөхөд л болно. Хуулиар ч тэр заавал үнэлгээ хийж байж, IPO гаргах ёстой гэсэн зохицуулалт бас байхгүй. Тийм учраас нээлттэй. СЗХ-ны хувьд бусад байгууллагуудад өгдөг зөвшөөрөл нь зургаан сарын хугацаатай байдаг. Тэгэхээр өнөөдөр зөвшөөрөл өгчихвөл энэ оныг дуустал ямар ч хугацаанд энэ хоёр банк хувьцаагаа гаргах нь нээлттэй. Мэдээж сүүлийн хоёр жилийн хугацаанд "Ковид-19"-тэй холбоотойгоор банкууд маш болгоомжтой байсан. Аль болох зээл бага гаргаж, зээлүүдэд бүтцийн өөрчлөлт их хийсэн. Тэрний үр дүнд аж ахуйн нэгжүүдэд ч тодорхой дэмжлэг болж очсон байх. Банкуудад ч эерэгээр нөлөөлсөн гэж Монголбанк харж байгаа. Яагаад гэвэл өнгөрсөн онд чанаргүй зээл 10 хувьтай байсан бол нэгдүгээр улирлын сүүлийн байдлаар 8.5 хувь болж буурсан. Тэгэхээр зээл төлөлт хэвийн болсон байна. Тийм учраас активын чанарын үнэлгээний үр дүн өөдрөг гарах хүлээлттэй байна. Статистик үзүүлэлтийг харвал, зээлийн өсөлт 20 гаруй хувьтай байна. Тэгэхээр зээл хэвийн олгогдож байгаа ч эрэлт, хэрэгцээ өндөр байна. Мөн банкуудын хувьд активын чанарын үнэлгээ хийлгэж байгаа, хувьцаагаа гаргах гээд бэлтгэж байгаа зэрэг олон ажлууд зэрэгцэж байгаа учраас зээл гаргаж байгаа процесс өмнөх шигээ хурдацтай явагдахгүй байх боломжтой. Нөгөө талаас нэгэнт олон нийтэд хувьцаагаа гаргах гэж байгаа банкны хувьд тодорхой хэмжээнд болгоомжлол байхыг үгүйсгэхгүй. Гэхдээ статистик, тоонуудыг харвал санхүүгийн тогтвортой байдал хэвийн хангагдаж байна.




СТАТИСТИК МЭДЭЭЛЛИЙН ТОЙМ

2022 оны 5 дугаар сар

ИНФЛЯЦ



2022 оны 3 дугаар сард бодлогын хүүг 2.5 нэгж хувиар өсгөж 9.0 хувьд хүргэв.



Эх сурвалж: Монголбанк

2022 оны 5 дугаар сарын байдлаар улсын хэмжээнд инфляц 15.1 хувьтай гарав.



ХҮНСНИЙ ҮНИЙН ЖИЛИЙН ӨӨРЧЛӨЛТ
УЛААНБААТАР
ХОТ



Мах, махан бүтээгдэхүүн 5.9%



Сүү, сүүн бүтээгдэхүүн 15.2%



Төрөл бүрийн өөх, тос 53.8%



Хүнсний ногоо 52.6%



Талх, гурил, будаа 22.5%




Сахар, жимсний чанамал, чихэр, шоколад 19.9%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо


M2 МӨНГӨ



M2 мөнгөний нийлүүлэлт 2022 оны 5 дугаар сард 27.5 их наяд ₮ хүрч, өмнөх оны мөн үеэс 1.2% -иар өсөв.



M2-ийн өсөлт байршуулалт талаас



M2-ийн өсөлт эх үүсвэр талаас




Эх сурвалж: Монголбанк


ЗЭЭЛ



2022 оны 5 дугаар сард банкуудын нийт зээлийн үлдэгдэл өмнөх оноос 27.6%-иар өсч 23.0 их наяд төгрөгт хүрэв.



2022 оны 5 дугаар сарын байдлаар чанаргүй зээл 9.2%-тай байна.



Зээлийн жилийн өсөлт, салбарын ангиллаар




Эх сурвалж: Монголбанк


ИПОТЕКИЙН ЗЭЭЛ



Ипотекийн нийт зээлийн үлдэгдэл **5,929.0** тэрбум төгрөгт хүрэв.



Шинээр олгосон ипотекийн зээлийн хүү



Зээлдэгчдийн тоо



Эх сурвалж: Монголбанк

ХҮҮ



Зээлийн хүү, хадгаламжийн хүүний зөрүү



Эх сурвалж: Монголбанк

Зээлийн хүү*, хугацаатай хадгаламжийн хүү
(*хөнгөлөлттэй зээл оруулснаар)




Эх сурвалж: Монголбанк


ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ



Төлбөрийн тэнцлийн динамик, сая ам.доллар




МУ-ын төлбөрийн тэнцэл 2022 оны эхний 4 сарын урьдчилсан байдлаар **942.8** сая ам.долларын алдагдалтай гарсан.



Урсгал ба хөрөнгийн дансны бүтэц



Санхүүгийн дансны бүтэц



Эх сурвалж: Монголбанк



ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ АВЛИГЫН ХООРОНДОХ ХАМААРАЛ

Д.ГАНТОГТОХ

Монголбанкны Олон нийтийн санхүүгийн
боловсролын төвийн эдийн засагч

Авлигалын тухай ойлголт нь нийгэм эдийн засагт хортой үр дагавартай болох ерөнхий ойлголт хүн бүрт бий. Авлига, хээл хахууль хэлцлийн зардлыг нэмэгдүүлж, эдийн засагт үр ашиггүй байдлыг бий болгох хандлагатай байдаг. Энэ талаар гадаадын болон дотоодын олон судалгаанууд хийгдсэн ба анхаарал татсан асуудал хэвээр байсаар байна.

Авлига эдийн засгийн өсөлтөд хэрхэн нөлөөлдөг талаар ерөнхийдөө хоёр төрлийн таамаглал, тэдгээрийг баталсан эрдэмтэн, судлаачдын эмпирик судалгааны ажлууд байдаг.

Тэдгээрийн эхнийх нь “Grease the wheels” буюу авлига нь үр ашиггүй зохицуулалтыг тойрон гардаг тул авлига эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлдэг гэж үздэг. Энэ нь бизнес эрхлэхтэй холбоотой зохицуулалт хатуу байгаа үед улс төрчид, хүнд сурталтнуудыг хахуульдах нь эдийн засгийн идэвхжлийг бий болгох магадлалтай гэж таамагладаг. Leff (1964), Huntington (1968), Friedrich (1972) нар авлига нь эдийн засгийн өсөлтөд ашигтай байх боломжтой гэж үзсэн. Хэрэв засгийн газар өргөн хүрээтэй, үр ашиггүй журам гаргасан бол авлига нь эдгээр зохицуулалтыг бага зардлаар тойрч гарахад тустай гэж тэд дүгнэсэн. Энэ нөлөөний дагуу авлига нь системийн үр ашгийг дээшлүүлж, эдийн засгийн өсөлтөд бодитоор эерэг нөлөөтэй байж болзошгүй юм.

Нөгөө нэг нь “Sand the wheels” буюу авлига нь үр ашигтай үйлдвэрлэл, инновацийг бий болгоход саад болдог учраас авлига нь эдийн засгийн өсөлтийг

бууруулдаг гэж таамагладаг. Эмпирик нотолгоо нь авлига нь ялангуяа хөрөнгө оруулалтын түвшин бага, засаглалын чанар муутай орнуудад эдийн засгийн өсөлтийг бууруулдаг болохыг харуулж байдаг (Жишээ нь: Mauro 1995, Tanzi 1997, Vishny 1993, Mo 2001, Aidt et al. 2008, Swaleheen 2011). Тухайлбал, авлига нь засгийн газрын зорилгыг өөрчилж, нөөцийг нийтийн хэрэгцээнээс хувийн хэрэгцээнд шилжүүлж, улмаар нийгэмд асар их хохирол учруулдаг болохыг тэд судалгаандаа онцолсон. Цаашилбал, төрийн авлига нь төрийн захиргааны зардлыг нэмэгдүүлэх замаар хувийн хөрөнгө оруулалтыг сааруулж болзошгүй (энэ нь төрийн албанд хахууль өгөх хэлбэрээр) эсвэл нийгэмд сэтгэл дундуур байх, улс төрийн үймээн самуун үүсгэх замаар эдийн засгийн өсөлтийг удаашруулж болзошгүй байдаг.

Авлигын талаарх ерөнхий ойлголт мэдээллийг өгч, харьцуулах боломжтой судалгаанд суурилсан хэмжүүрүүд харьцангуй цөөн бөгөөд тус үзүүлэлтийг үнэлэхэд бэрхшээлтэй байдаг. Үүнээс дэлхий дахинд өргөн ашиглагддаг Транспаренси Интенэйшнэл байгууллагаас гаргадаг Corruption Perception Index (CPI)¹-ийг авлигыг хэмжих үзүүлэлтээр төлөөлүүлэв. Дэлхийн улс орнуудын авлигын индексийн дундаж сүүлийн арван жил өөрчлөгдөөгүй хэвээр бөгөөд боломжит 100 онооноос 43 оноо аваад байгаа юм. Улс орнууд авлигын эсрэг арга хэмжээ авах

¹ Тус Авлигын индекс (Corruption Perceptions Index, CPI) -ыг 0-оос 100 хүртэлх оноогоор үнэлэж улсуудын авлигын зэрэглэлийг тогтоодог бөгөөд 0 рүү дөхөх тусам авлигын түвшин өндөр, 100 руу дөхөх тусам авлигалын түвшин бага буйг илтгэдэг.

шаардлагатай байгаа ч сүүлийн 10 жилд 131 улс авлигын эсрэг дорвитой ахиц дэвшил гаргаагүй байна. Тухайлбал, дэлхийн улс орнуудын гуравны

хоёр нь 50-иас доош оноо авсан нь дэлхий дахин авлигын ноцтой асуудалтай байгааг харуулж байна.


Зураг 1. Дэлхийн улс орнуудын авлигын индекс- 2021



2021 онд 182 орны авлигын индексийг тооцож зэрэглэл тогтоосон бөгөөд доорх зургаас харахад Дани улсын авилгын индекс нь 88 буюу авилгын түвшин бага, улмаар институцийн чанар сайн байгааг (Зураг 1) илтгэж байна. Хамгийн бага оноотой буюу авлига өндөртэй орнуудын ихэнх нь Африкын жижиг буурай хөгжилтэй улсууд байна. Буурай бага орлоготой эдгээр орны хувьд хүн ам цөөтэй, техник технологи сайн хөгжөөгүйгээс гадна засаглалын чанар байх ёстой түвшнөөсөө доогуур, хээл хахууль өндөртэй зэрэг нь авлигын индекс 0 оноо руу дөхөх шалтгаан нь болж байна. Монгол Улсын хувьд 2021 оны байдлаар 35 оноотой 180

улсаас 110 дугаар байранд (Зураг 2) жагсаж байна. Манай улсын хувьд тус авлигын индекс өндөр түвшинд байгаа үндсэн шалтгаан нь төрийн албан хаагчид эрх мэдэл, албан тушаалын байдлаар урвуулан ашигладаг байдал нэмэгдсэнээс хамаарсан байж болох судалгааны дүн гарсан (Corruption Perception Index Report, 2021). "Global Insite" байгууллагаас гаргадаг авлигын эрсдэлийн түвшний үнэлгээгээр 12 оноогоор буурсан төдийгүй бизнес эрхлэгчид үйл ажиллагаа эрхлэх болон гэрээ, хэлцэл байгуулах ажиллагаанд авлигатай нүүр тулах эрсдэл нэмэгдсэн гэх шалтгаанаар үнэлгээ буурч, хойгуур байранд хэвээр байна.

Зураг 2. Монгол Улсын авлигын индекс ба жагсаж буй байр



Эх сурвалж: Transparency International

Цаашлаад авлига ба эдийн засгийн өсөлтийн хамаарлын эмпирик шинжилгээг A.Rivera-Batiz болон Paul M.Romer нарын эдийн засагчдын (Economic growth and Endogenous growth. 1990) нээлттэй 2 улсын эдийн засгийн хувьд боловсруулсан загварыг Francisco L.Rivera-Batiz (International Financial Liberalization, Corruption, and Economic Growth, 2001) авлига оролцсон жижиг нээлттэй эдийн засгийн хувьд боловсруулсан дотоод өсөлтийн загварын өргөтгөл дээр суурилан авч үзсэн. Шинжилгээндээ өндөр хөгжилтэй болон бага, дунд орлоготой нийт 110 улсын 2004-2021 оны хугацааг хамарсан панел тоон мэдээлэл дээр шинжилгээг хийж харьцуулсан. Судалгааны үр дүнд авлигын эдийн засагт үзүүлэх нөлөө нь “Sand the wheels” буюу авлига нь эдийн засагт үр ашиггүй, сөрөг нөлөөтэй нь харагдсан. Улс орнуудын орлогын ялгаатай байдлаар авлигын нэг хүнд ногдох бодит ДНБ-д хэрхэн нөлөөлж буйг авч үзэхэд бага, дунд орлоготой орнуудын эдийн засагт

үзүүлж буй авлигын нөлөө нь өндөр орлоготой орнуудтай харьцуулахад илүү сөрөг нөлөөтэй гэсэн үр дүн гарсан. Шинжилгээний хүрээнд авч үзсэн бусад хамааран хувьсагчид болох боловсролын индекс, капиталын зэвсэглэмж зэрэг нь нэг хүнд ногдох бодит ДНБ-д эерэг нөлөөтэй байна. Монгол Улсын хувьд хугацаан цуваан өгөгдлийг ашиглан авлига, эдийн засгийн хамаарлыг авч үзэхэд авлигын индекс нэг хувиар өсөхөд нэг хүнд ногдох бодит ДНБ-ийг 0.29 хувиар бууруулах нөлөөг үзүүлсэн. Энэ нь бага, дунд орлоготой орнуудын эдийн засагт үзүүлж буй дундаж нөлөөнөөс давсан үзүүлэлт юм. Эцэст нь тус судалгаанаас авлига нь манай орны эдийн засагт сөрөг нөлөө үзүүлдэг чухал хүчин зүйлсийн нэг болсон төдийгүй улс төр, нийгэм эдийн засаг, бизнесийн бүхий л салбаруудад жил ирэх тусам сөрөг нөлөөлөл, хор уршиг нь өссөөр байгаа нь судалгааны явцад ажиглагдсан.



ADB

PSM)))
PROJECT



ЗАЙНААС
УНШУУЛ



EMV технологийн стандартын нууцлал,
аюулгүй байдлын нэмэгдүүлсэн



Үйлчилгээний түргэн шуурхай байдлыг хангав



Мөнгөн дүнгийн тодорхой хязгаар дотор
ПИН код шаардахгүй



Нийтийн тээвэр, зогсоол, замын төлбөр
төлөхдөө ч зайнаас уншуулж ашиглана



Мобайл төлбөр тооцоонд нэвтэрсэн
шинэ төрлийн шийдэл

1. EMV ЧИП ТЕХНОЛОГИ ГЭЖ ЮУ ВЭ?

“EMV” нь ухаалаг чиптэй төлбөрийн картыг хэлдэг бөгөөд үүсгэн байгуулагч Europay, MasterCard, Visa зэрэг байгууллагуудын нэрийн товчлол юм. EMV стандарт нь ухаалаг чиптэй картын дэлхий даяар хэрэглэгддэг аюулгүй байдлын технологи юм.

2. EMV ЧИП ТЕХНОЛОГИЙГ ДЭЛХИЙН ХЭЧНЭЭН УЛС ОРОНД АШИГЛАЖ БАЙНА ВЭ?

2022 оны нэгдүгээр улирлын байдлаар дэлхийн нийт төлбөрийн картын 68.2% буюу 11 тэрбум гаруй картад EMV технологи нэвтрүүлсэн байна.

3. ҮНДЭСНИЙ БРЭНД ₮ КАРТ EMV ЧИП ТЕХНОЛОГИД СУУРИЛСНААР ЯМАР ДАВУУ ТАЛ, АЧ ХОЛБОГДОЛТОЙ БОЛЖ БАЙГАА ВЭ?

Үндэсний брэнд ₮ карт EMV чип технологид суурилснаар олон улсын жишгийн дагуу нууцлал, аюулгүй байдал сайжрах төдийгүй, ирээдүйд мобайл төлбөр тооцооны дэвшилтэд технологийг нэвтрүүлэх суурь шийдэл юм. EMV чип бүхий ₮ картыг хуулбарлах, хулгайн болон залилангийн гүйлгээний эрсдэлээс хамгаалах ба карт эзэмшигчид EMV чиптэй ₮ картыг ашиглахад илүү хялбар, үр ашигтай болсон. Үүгээр зогсохгүй чип технологид суурилсан төлбөрийн болон урамшууллын шинэ үйлчилгээ нэвтрүүлэх, чип картыг зайнаас (NFC) уншуулж мөнгөн дүнгийн тодорхой хязгаар дотор ПИН кодгүй гүйлгээ хийх, нийтийн тээвэр, авто зогсоол, замын төлбөр гэх мэт бага дүнтэй, олон тооны гүйлгээ шуурхай хийгдэх шаардлагатай газруудад төлбөрийн картыг ашиглах боломж бүрдсэн. Үүнээс улбаалж арилжааны банкууд болон финтек компаниуд шинэ төлбөрийн үйлчилгээ нэвтрүүлэх бүрэн бололцоотой болж байна.

4. ҮНДЭСНИЙ БРЭНД ₮ КАРТ ГЭЖ ОНЦЛОХ НЬ ЯМАР УЧИРТАЙ ВЭ?

Монголбанк нь үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгийг бэлгэдэн нэрлэсэн үндэсний брэнд “₮-карт”-ыг Монгол Улс дахь арилжааны банкуудтай хамтран гаргах ажлыг 2012 онд амжилттай зохион байгуулж, төлбөрийн системийн хөгжилд чухал ач холбогдол бүхий алхам хийсэн. 2022 оны нэгдүгээр улирлын байдлаар 2.6 сая ширхэг ₮ карт ашиглагдаж байгаа бөгөөд энэ нь нийт картын зах зээлийн 58.4 хувийг эзэлж байна.

5. МАНАЙ УЛСАД ҮНДЭСНИЙ БРЭНД ₮ КАРТААС ӨӨР ТӨРЛИЙН КАРТ АШИГЛАГДДАГ УУ?

Манай Улсад ₮ картаас гадна Виза, Мастеркарт, ЮнионПэй, Америкс, ЖэйСиБи зэрэг олон улсын төлбөрийн картууд ашиглагддаг.

6. ҮНДЭСНИЙ БРЭНД ₮ КАРТЫН НУУЦЛАЛ, АЮУЛГҮЙ БАЙДАЛ ХЭР БАТАЛГААТАЙ ВЭ?

Олон улсын жишгээр EMV стандартын дагуу нууцлал, аюулгүй байдлын хангасан болно.

7. ҮНДЭСНИЙ БРЭНД ₮ КАРТЫГ ӨӨР УЛС ОРОНД АШИГЛАЖ БОЛОХ УУ?

Одоогийн байдлаар ₮ карт нь зөвхөн МУ-ын нутаг дэвсгэр дээр ашиглагдана.

8. АРИЛЖААНЫ БАНКУУДААС ЗАХИАЛЖ АВСАН ₮ КАРТУУД ӨӨР ХООРОНДОО ЯЛГААТАЙ ЮУ?

Тухайн арилжааны банкнаас хамааран ₮ карт нь өөр өөрийн өнгө дизайн, урамшуулал, үйлчилгээний нөхцөлөөр ялгарах боломжтой.

9. ҮНДЭСНИЙ БРЭНД ₮ КАРТЫГ ЗАХИАЛЖ АВАХАД ЯМАР НЭГЭН ШАЛГУУР БИЙ ЮУ?

Та аль нэг арилжааны банканд төгрөгийн харилцах данстай байхад хангалттай.

10. ҮНДЭСНИЙ БРЭНД ₮ КАРТЫГ ХЭРХЭН ЗАХИАЛЖ АВАХ ВЭ?

Та өөрийн харилцдаг банкаараа дамжуулан EMV чип бүхий ₮ картаа захиалан авна.



КОРРЕСПОНДЕНТ БАНКНЫ ХАРИЛЦААНЫ КӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны олон улсын стандарт 2012 онд шинэчлэгдсэн бөгөөд улмаар улс орнуудын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог үнэлэх аргачлал давхар шинэчлэгдэж, хууль тогтоомжийн үр дүнтэй хэрэгжилтэд нэлээд ач холбогдол өгөх болсон. Улс орнууд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны үр дүнтэй байдлыг нэмэгдүүлэх зорилгоор хяналт, зохицуулалт, хариуцлагын тогтолцоог чангаруулж эхэлсэн нь банк, санхүүгийн байгууллагын эрсдэлийн удирдлагын арга хэлбэрт тодорхой хэмжээнд нөлөөлж эхэлсэн [1]. Түүнчлэн 2008 оны санхүүгийн хямралаас хойш дэлхийн томоохон банк, санхүүгийн байгууллагуудын эрсдэлийн удирдлагын арга хэлбэрт ихээхэн өөрчлөлт гарч, эрсдэлээс зайлсхийх хандлага бий болсон [2].

Дээрх үйл явдлуудын нөлөөгөөр дотоодын болон хил дамнасан төлбөр тооцоог найдвартай, түргэн

шуурхай хийх боломжийг олгодог корреспондент банкны харилцааг тогтоох эсэх шийдвэр нь комплаенсын эрсдэл, зардал, үр ашгийн тооцоонд суурилсан хэлбэрт шилжээд байна.

1. Монгол Улсын гадаад төлбөр тооцоо банкны системээр дамжих байдал

Монгол улсын гадаад худалдааны эргэлт 2021 онд 16.1 тэрбум ам.доллартай тэнцүү байна. Үүнээс экспортын орлого 9.2 тэрбум ам.доллартой, импорт 6.8 тэрбум ам.доллартой тэнцүү буюу Монгол Улс жилд эдийн засгийн нөхцөл байдлаас хамааран ойролцоогоор 6.1-6.8 тэрбум ам.долларын импортын бараа үйлчилгээг гадаад зах зээлээс авч байна. Харин 2022 оны эхний 2 сарын байдлаар гадаад худалдааны эргэлт 2.2 тэрбум ам.доллартай тэнцүү байгаа ба үүнээс экспортын орлого 1.2 тэрбум ам.доллар, импорт 1 тэрбум ам.доллартой тэнцүү байна (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Гадаад худалдааны жилийн урьдчилсан гүйцэтгэл, сая ам.доллар

Төрөл	Жилээр			Эхний 2 сар			Өөрчлөлт	
	2019	2020	2021	2020	2021	2022	2022/2021	
							Дүн	Хувь
Эргэлт	13,747	12,875	16,096	1,521	2,257	2,218	-39	-2%
Экспорт	7,620	7,576	9,247	771	1,335	1,180	-154	-12%
Импорт	6,128	5,299	6,849	750	922	1,038	115	13%
Тэнцэл	1,492	2,277	2,398	21	412	143	-270	


Эх сурвалж: Гадаад худалдааны тойм 2022 оны 2-р сар, Монголбанк

Тус гадаад зах зээлээс авч байгаа импортын бараа үйлчилгээний төлбөрийн 90-95 хувь нь банкны системээр дамжин хийгддэг байна. Харин экспортын орлогын ойролцоогоор 70-75 хувь нь банкны системээр дамжин Монгол Улсад орж ирдэг байна.




Гадаад гүйлгээний орох болон гарах урсгалын хувьд ам.доллар нь нийт урсгалын дийлэнхийг бүрдүүлж байна. Тухайлбал, орох урсгалын 81.55 хувь, гарах урсгалын 66.96 хувийг бүрдүүлж байна. Харин урсгалд их дүн эзэлж буй дараагийн валют нь юань байна. Орох урсгалын хувьд 14.61%, гарах урсгалын хувьд 15.91%-ийг эзэлж байгаа юм (Зураг 1).

Зураг 1. 2021 оны гадаад гүйлгээний орох болон гарах урсгал, валютын эзлэх хувиар



Гарах урсгал




Эх сурвалж: Гадаад гүйлгээний мэдээлэл, Монголбанк

2. Монгол Улсын корреспондент банкны харилцааны өнөөгийн байдал

Хэрэглээнд суурилсан Монгол Улсын эдийн засаг нь гадаад худалдааны тогтвортой байдал, түүний төлбөр тооцоог хүндрэлгүй гүйцэтгэх чадвараас ихээхэн хамаарч байдаг. Сүүлийн жилүүдэд арилжааны банкуудын АНУ-д төвтэй корреспондент банкны харилцаа буурч, ам.долларын гадаад гуйвуулгын гүйлгээг бусад улсын харилцагч банкаар дамжуулан хийх болсон. 2013 оноос хойш гаднын зарим банкууд Монгол Улсын арилжааны банкуудтай корреспондент харилцаагаа цуцалж эхэлсэн байдаг. Энэ нь нэгдүгээрт, Монгол Улс ФАТФ-ын саарал жагсаалтад орсон; хоёрдугаарт, комплаенсын зардал өссөнөөр гадаад төлбөр тооцооны зардал нэмэгдсэн; гуравдугаарт, олон улсын болон дотоодын байгууллагын хууль, журам чангарсантай холбоотой удирдлагын шийдвэрээр цуцлах зэргээс үүдэлтэй юм. Монгол Улсад үйл ажиллагаа эрхэлж буй нийт арилжааны банкууд 2022 оны 2 дугаар улирлын байдлаар нийт гадаадын 51 банктай корреспондент банкны харилцаатай байгаа ба гадаад валютын нийт 339 ностро данс эзэмшиж (Зураг 2), олон улсын мөнгөн гуйвуулга, гадаад төлбөр тооцоог гүйцэтгэж байна. Үүнээс ам.долларын данс 34 хувь, еврогийн данс 10 хувь, юанийн данс 18 хувь, 12 хувийг рублийн данс болон бусад валютын дансны мэдээллийг дор дэлгэрэнгүй харуулав (Зураг 4).


Зураг 2. Арилжааны банкуудын корреспондент банкны тоо (2022 оны 2 дугаар улирал)*



Эх сурвалж: Банкуудаас ирүүлсэн тайлан, Монголбанк, СМА

Дээрх банкуудын харилцагч корреспондент Монгол Улсын хөрш орнууд болох БНХАУ болон банкны байршуудыг авч үзвэл дийлэнх хэсгийг ОХУ-д байрлах банкууд эзэлж байна.


Зураг 3. Нийт корреспондент банкуудын байршил /тоогоор/ (2022 оны 2 дугаар улирал)



Эх сурвалж: Банкуудаас ирүүлсэн тайлан, Монголбанк, СМА

*Банк 1-10 гэдэг нь төлбөрийн үйл ажиллагаа эрхэлж байгаа байгууллагуудын нэрийг нууцлалаар тайлбарлав.

Зураг 4. Гадаад улсын корреспондент банканд байршилтай нийт ностро дансанд эзлэх валют тус бүрийн эзлэх хувь



Эх сурвалж: Банкуудаас ирүүлсэн тайлан, Монголбанк, СМА

Иймд дүгнэж харахад Монгол Улсын өнөөгийн корреспондент банкны харилцаанд ностро дансуудын хувьд нийт ностро дансны 34 хувийг эзэлж байгаагаар ам.долларын данс давамгайлж байна. Ам.долларын данс дийлэнхийг бүрдүүлдэг боловч газар зүйн байршлын хувьд АНУ-д төвтэй ямар ч банктай корреспондент банкны харилцаагүй байна.

Ашигласан материал:

- [1] Олонулсын төлбөртооцооны банк. "Correspondent banking." *BIS.org*. Jul.2016, <https://www.bis.org/cpmi/publ/d147.pdf>
- [2] Дэлхийн банк. "Withdrawal from correspondent banking Where, Why, and What to Do About it."

Finance and Markets Global Practice, The World Bank Group. Nov.2015, 101098-revised-PUBLIC-CBR-Report-November-2015 (1).pdf

- [3] Дэлхийн банк. "An analysis of trends in cost of remittance services. Remittance prices worldwide quarterly." *The World Bank Reports, Issue 39*. Sep.2021, https://remittanceprices.worldbank.org/sites/default/files/rpw_main_report_and_annex_q321.pdf
- [4] Европын төв банк. "Eleventh survey on correspondent banking in euro." *ECP Europa Publications*. Nov.2020, <https://www.ecb.europa.eu/pub/pdf/other/ecb.eleventhsurveycorrespondentbankingeuro202011~c280262151.en.pdf>

МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ХОРООНЫ ХАРААТ БУС ГИШҮҮД ЮУ ХЭЛЭВ?

Мөнгөний бодлогын хорооны II улирлын хуралдаанаас гаргасан шийдвэрийн талаар Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны хараат бус гишүүн Ч.Хашчулуу, Ц.Мөнхбаяр нарын хэвлэлд өгсөн ярилцлагыг тоймлов.



Ч.ХАШЧУЛУУН
МБХ-ны гишүүн

МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ШИЙДВЭРТ НӨЛӨӨЛСӨН ГОЛ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ТАЛААР МЭДЭЭЛЭЛ ӨГНӨ ҮҮ?

Гадаад нөхцөл байдлаа харвал бид дэлхий даяар түүхэнд байгаагүй том инфляцын давлагаанд орж байна. Энэ давлагаа нь зөвхөн Монгол Улсад ч биш АНУ, Европ гээд бүхий л улс орнуудад бий болсон. Ийм инфляцын давлагаа урьд өмнө нь төдийлөн байгаагүй. Бүр түүхийг сөхөөд үзвэл 1970-аад онд газрын тосны үнийн шок болж, шатахууны үнэ 4 дахин нэмэгдэж байлаа.

Хоёрдугаарт, дэлхий эдийн засгийн хувьд маш тогтворгүй байна. Энд тэнд дайн дажин болж, ложистикийн том асуудал хэвээрээ үргэлжилж, үйлдвэрлэлийн хямрал нэмэгдэж гарч ирлээ. Яагаад гэвэл дэлхийн хамгийн том үйлдвэрлэгч улс болох урд хөршийн гол хотуудад хориг тавигдсанаас болж үйлдвэрлэлийн процесс тасалдаж, эд ангиуд нь олдохгүй байгаа. Тийм учраас энэ нь дэлхийн хэмжээнд үнийн өсөлтөөр илэрч байгаа эдийн засгийн тогтворгүй байдал бий болж байна. Дотоодын эдийн засгийг аваад үзвэл эдийн засгийн өсөлт сайн гарч чадахгүй байгаа. Сүүлийн улирлуудад хасах гарлаа. Манайх импортын маш их бараа хэрэглэдэг учраас үнийн өсөлт зэрэгцээд бий болж байгаа. Ийм тохиолдолд бид төгрөгийн ханшийг хамгаалах шаардлагатай юм.

ИНФЛЯЦЫН ТҮВШНЭЭС ХАМААРЧ МОНГОЛБАНК МӨНГӨНИЙ БОДЛОГЫГ ЦААШИД ЧАНГАЛНА ГЭДЭГ ДОХИОГ ӨГЧ БАЙНА. ОЛОН УЛСЫН ХЭМЖЭЭНД Ч ГЭСЭН ТӨВ БАНКУУД ЭНЭ ОНД ХЭД ХЭДЭН УДАА БОДЛОГОО ЧАНГАРУУЛАХАА МЭДЭГДСЭН. ЦААШИД ХЭДЭН ХУВИАР НЭМЭГДҮҮЛЭХ БОЛ?

Эдийн засгийн шинжлэх ухаанд валютын ханшийг тогтоохдоо “тэнцвэр хадгалах” гэдэг ойлголтыг ашигладаг. Долларын ханш хүүтэй хамааралтай. Сая АНУ-ын Холбооны нөөцийн банкны хүү нэмэгдсэнтэй холбогдуулан яг тэр хэмжээгээр ханшийн харьцааг хамгаалахын тулд дор хаяж төгрөгийн өгөөжийг нэмэгдүүлэх шаардлагатай болж байгаа. Тэр талаас нь аваад үзвэл бодлогын хүүг цааш нэмэгдүүлэх шаардлага гарах байх. Доллар, төгрөгийн өгөөжийг тэнцүүлэх шаардлага байгаа тул Америкийн төв банк хүүгээ нэмэгдүүлэх төлөвтэй тул манайх ч гэсэн цаашид хүүгээ өсгөх болно.

ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГУУД МАНАЙ УЛСАД СТАГФЛЯЦЫН ЭРСДЭЛИЙГ АНХААРУУЛЖ, ЗӨВЛӨЖ ӨГСӨН БАЙГАА. МОНГОЛБАНКНЫ ЗҮГЭЭС СҮҮЛД МЭДЭЭЛСНЭЭР СТАГФЛЯЦ ҮҮСЭХ НӨХЦӨЛ ХАРАГДАХГҮЙ БАЙГАА ГЭСЭН МЭДЭЭЛЭЛ ӨГСӨН. ТАНЫ БАЙР СУУРЬ ЯМАР БАЙГАА ВЭ?

Стагфляц гэдэг нь 1980-аад оны эхээр бий болсон онолын ойлголт. Үйлдвэрлэл унаж байгаа, юмны үнэ өсөж байгаа байдлыг зэрэг харуулдаг.

Манай нөхцөл байдлыг харвал стагфляцын шинж чанар байна. Бодит үйлдвэрлэл буурч, юмны үнэ өсөөд байгаа. Үүнээс гарах аргууд өндөр хөгжилтэй орнуудад бий. Жишээ нь 1980-аад онд үед Рейган ерөнхийлөгч нийлүүлэлтийн бодлогыг хэрэгжүүлсэн гэж ярьдаг. Мөн өргөн хэмжээний хувьчлал явуулж, төрийн зардал бууруулж, хүчтэй долларыг хэрэгжүүлэх бодлогыг хэрэгжүүлж байсан. Монголын хувьд энэ бол харьцангуй шинэ үзэгдэл гэж хэлж болно. Яах вэ 1990-ээд онд үйлдвэрлэл унаж, юмны үнэ өсөж байсан ч тэр нь шилжилтийн хямралын нөлөө. Одоогийнх бол дэлхийн эдийн засагтай холбоотой хямрал учраас ийм нөхцөл байдалтай анх удаагаа тулгарч байна гэж хэлж болно. Тийм учраас цаашид гарахыг үгүйсгэхгүй. Тиймээс эдийн засгийн бодлогын хувьд өөр хандах шаардлагатай болох байх. Ямар ч байсан эхний ээлжид төгрөгийн ханш, өгөөжийг зайлшгүй хамгаалах ёстой.



Ц.МӨНХБАЯР
МБХ-ны гишүүн

ОЙР ОЙРХОН ХУГАЦААНД БОДЛОГЫН ХҮҮГ НЭМЭГДҮҮЛЭХ НЬ ЭРГЭЭД ЭДИЙН ЗАСАГТ ЯМАР НӨЛӨӨТЭЙ БАЙХ ТАЛААР БАЙР СУУРИА ИЛЭРХИЙЛНЭ ҮҮ?

Монголбанкны Мөнгөний бодлогын хороо нь улирал тутам хуралдаж мөнгөний бодлогын хүүгийн талаар шийдвэр гаргадаг. Энэ удаагийн хурлаар бид бодлогын хүүг нэг нэгж хувиар нэмэгдүүлж хоёр оронтой тоо болгосон нь дунд хугацаанд инфляцыг тогтворжуулах, эдийн засгийн өсөлтийг дэмжихэд чиглэсэн шийдвэр юм. Инфляцын түвшин улсын хэмжээнд 15%, нийслэлд 16% хүрээд байна. Эдийн засагт үүсэж буй геополитикийн асуудал, тээвэр ложистикийн хүндрэл зэрэгтэй холбоотойгоор нийлүүлэлтийн гаралтай инфляц ихээхэн нэмэгдэж байна. Энэ инфляцыг дунд хугацаанд тогтворжуулахын тулд мөнгөний бодлогын төлөвөө үе шаттайгаар хатууруулж байна гэсэн үг.

АЛЬ БОЛОХООР ҮЙЛ АЖИЛЛАГААГАА ХЭВИЙН ЯВУУЛАХ ГЭЖ БАЙГАА БИЗНЕС ЭРХЛЭГЧДЭД БОДЛОГЫН ХҮҮ ДАРАМТ БОЛОХ ЭРСДЭЛ БИЙ ЮУ. БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙН ХУВЬД ЭНЭ ШИЙДВЭР ХЭРХЭН НӨЛӨӨЛӨХ ВЭ?

Инфляц, бодлогын хүүгийн төлөвөө харвал бид хүүгээ үүнээс хэд дахин их буюу 2-3 нэгж хувиар нэмэгдүүлэх шаардлага байгаа. Гэхдээ дөнгөж сэргэж эхэлж буй уул уурхайн бус салбарын өсөлтийг цааш хадгалах шаардлагатай. Бусад салбарын өсөлт байвал эдийн засгийн тэнцвэр тогтвортой байна. Тэр агуулгаар нь бодлогын хүүгээ нэг нэгж хувиар нэмэгдүүлсэн байгаа. Хоёр дахь анхаарч авч үзсэн юм бол гол нэр төрлийн зарим бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомстлоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах хууль батлагдсан. Нэг талаас бодлогын хүүгээ өсгөж буй ч нөгөө талаас мөнгө нийлүүлж буй

тохиолдолд хүүг хэт өндөр хувиар өсгөх боломжийг хязгаарлаж байгаа. Тэгэхээр үүнийг хараат бус гишүүнийхээ хувьд инфляцыг тогтворжуулах үүргийг УИХ-аар өгч байгаа ч нөгөө талаас тийм эрх зүйн орчныг бүрдүүлчихээр бодлогын зөрчлийг бий болгоод байна. Тэгэхээр аль аль талаа харгалзан үзээд бодлогын хүүг нэг нэгж хувиар нэмэгдүүлсэн.

**МӨНГӨНИЙ БОДЛОГОТОЙ ТӨСӨВТЭЙ УЯЛДАЖ БАЙЖ ЗӨВ ШИЙДВЭР
БОЛНО ГЭЖ ҮЗДЭГ. МАНАЙ УЛСЫН ХУВЬД ТӨСВИЙН САХИЛГА БАТ
ХЭРЭГЖИЖ БАЙНА УУ, МӨНГӨНИЙ БОДЛОГОТОЙ УЯЛДАЖ БАЙГАА ЮУ?**

-Манай улсын хувьд төсөв нь өөрөө уян хатан, алдагдал хамгийн бага байж хувийн хэвшилдээ орон зай гаргаж өгдөг. Хэрэв төсөв өндөр алдагдалтай байвал хувийн хэвшил дэх хөрөнгө оруулалтыг шахна. Мөн эдийн засагт мөнгөний нийлүүлэлт нэмэгдэж, эдийн засаг тэлбэл бодлогын хүүг өсгөдөг, энэ нь өөрөө хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг багасгадаг талтай. Бид илүү төсвийн сахилгат баттай байж, алдагдал бууруулах чиглэлд хийгдэнэ гэж үзээд инфляцын тооцоолол бага байсан. Саяны төсвийн тодотгол санасанд хүртэл хийгдэж чадаагүйтэй холбоотойгоор инфляцын тооцоолол харьцангуй сул гарсан. Төсвийн төлөв чангарна гэх хүлээлт сул байсан нь бодлогын хүүгийн өсөлтөд нөлөөлж байна.




МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

Монголбанкны үнэт металл худалдан авалт 2022 оны 5 сар

Үнэт металл худалдан авалт

Монголбанк 2022 оны 6 дугаар сард 1,962.6 кг үнэт металл худалдан авч, оны эхнээс өссөн дүнгээр 7.9 тонн үнэт металл худалдан аваад байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 16 хувиар буурсан үзүүлэлт байна.


Оны эхнээс өссөн дүнгээр Дархан-Уул аймаг дахь Монголбанкны хэлтэс 490.6 кг, Баянхонгор аймаг дахь Монголбанкны хэлтэс 491.0 кг үнэт металл тус тус худалдан авсан.



эх сурвалж: Монголбанк

Үнэт металлын үнэ

Монголбанкны үнэт металл худалдан авах үнийг дэлхийн зах зээл дээрх үнээр тогтоодог. 2022 оны 6 дугаар сард **дундаж үнэ 193,390.83** төгрөг байв.



эх сурвалж: Монголбанк



“ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ФОРУМ-2022” ЭЭЛЖИТ ХУРАЛ

Профессор Клаус Швабын хэлсэн үг

Эшлэл үгс

- Давос 2022 нь 50 жилийн өмнө анх чуулж байсан уулзалтуудаас хамгийн цаг үеэ олсон ба үр дүнтэй хурал боллоо.
- Давос нь дэлхий дахины болоод нийгмийн бүх төрлийн удирдагчдыг биечлэн уулзуулдаг
- Давосын хурал зохион байгуулж буй газар нь хамгийн найрсаг уур амьсгалыг бүрдүүлдэг ч нөгөөтэйгүүр хамгийн зөрчилтэй нь ч байж болно..

Энэ жил Давосын Дэлхийн эдийн засгийн чуулга уулзалт “Түүхийн эргэлтийн цэг” уриан дор болж байгаа нь 50 гаруй жилийн өмнө тус уулзалт зохион байгуулагдснаас хойших хамгийн цаг үеэ олсон, үр өгөөжтэй хурал байх болно. Давосын уулзалт нь дэлхийн томоохон удирдагчдыг биечлэн уулзуулж, засгийн газрын бодлого, бизнесийн стратегийн үр дагаврыг хэлэлцэнэ.

Украин

Бидний эхний бодох зүйл бол Украин дахь дайнтай холбоотой асуудал юм. Оросын Холбооны Улсын энэхүү түрэмгийлэл нь Дэлхийн хоёрдугаар дайн, хүйтэн дайны үеийн дараах уналт хэмээн ирээдүйд түүхийн номонд бичигдэх болов уу. Энэ нь түүхийн эргэлтийн цэгийн тухай эргэн ярих нэгэн шалтгаан юм. Иймд дайны харгис хэрцгий байдлаас болж зовж шаналж буй ард түмний төлөөх бидний эв санааны нэгдэл бол Давос байх болно.

Энэ дайн миний хувьд бас хувийн чанартай. Учир нь би хоргодох байранд суугаад бөмбөг

дэлбэрэлтийг сонсож байсан нь миний бага насны дурсамжинд хоногшин үлдсэн. Гэсэн ч Европт ахин дайн байлдаан болно хэмээн би өмнө нь төсөөлж байгаагүй.

Давосын уулзалтаар бид Украины ард түмний сэргэлтийг дэмжихийн тулд чадах бүхнээ хийх учиртай. Түүнчлэн дэлхийн эдийн засгийн форум хэзээ нэгэн цагт дахин энх тайван дор зохион байгуулагдах болно гэж найдаж байна.

Давос 2022-ыг энэ жил цагаа олсон гэж тодотгох өөр нэмэлт шалтгаанууд бий.

Ковид-19

ДЭМБ-ын мэдээлсэнчлэн сүүлийн 100 жилийн хугацаанд эрүүл мэндэд учирсан хамгийн том гамшиг буюу 15 сая хүнийг үхэлд хүргэсэн КОВИД-19 цар тахлын төгсгөл ирнэ гэж бид бүгд найдаж байна. Тиймээс “Бид ирээдүйд зөвхөн вирусын эсрэг төдийгүй бидний амьдралын хэв маягийг сүйтгэсэн зүйлсийн эсрэг, илүү сайн бэлтгэлтэй байхын тулд шаардлагатай хувь хүний, үндэсний болон дэлхийн дасан зохицох чадавх, механизмыг хэрхэн хөгжүүлэх вэ?” гэсэн хамгийн том асуулттай тулгарлаа.

Уур амьсгалын дээд хэмжээний уулзалт

Байгаль, цаг уураа хамгаалах асуудал илтэд хамгийн түрүүнд санаанд орж байна. Хүн төрөлхтөнд одоогийн хандлагаа өөрчлөх хэдхэн жилийн хугацаа үлдээд байгааг бид бүгд мэднэ. Энэхүү боломжийг ашиглах хугацаа ч мөн адил

багасаж байна. Тиймээс 2022 оны Давосын уулзалт нь уур амьсгалын өөрчлөлтийн асуудлыг хөндөх дээд хэмжээний чуулган байх ёстой. Үүний тулд чухал оролцогчдыг нэгтгэн, тухайн чиглэлээрх бүх санаачлагыг хэрэгжүүлэх нь чухал юм. НҮБ-ын Уур амьсгалын дээд хэмжээний уулзалтын COP 26 дээр эхлүүлсэн “First Mover Coalition”; “One Trillion Trees” гэх мэт бусад төслүүд багтана. Түүнчлэн эрчим хүчний өөрчлөлтийг дэмжих нь Давосын хэлэлцүүлэгүүдийн нэг байх болно.

Дайн, цар тахал болон уур амьсгалын өөрчлөлт нь дэлхийн сэргэлтийн явцыг алдагдуулж байна. Жишээ нь инфляц сүүлийн хэдэн арван жилд ийм өндөр байгаагүй юм. Худалдан авах чадвараа алдаж, амьжиргааны эх үүсвэрээ хангахад бэрхшээлтэй тулгарч буй хүмүүст хамгийн их санаа зовж байна.

Дэлхийн эдийн засаг

Дэлхийн эдийн засаг тогтворгүй байна. Хэт их өр, хэт өндөр инфляц, хэт өндөр тэгш бус байдал болон эдийн засгийн хангалтгүй өсөлт зэрэг асуудал байсаар байна. Ялангуяа, дэлхийн хүн амын дийлэнх хэсэг нь оршин тогтнох эсэх сонголттой нүүр тулж, тэр ч байтугай хэт ядуурал, өлсгөлөнд нэрвэгдэх болсон нь анхаарал татаж байна. Эдгээр асуудлуудыг Давос хэлэлцэх ёстой бөгөөд ялангуяа дэлхийн хүнсний хомсдолд бид нэн даруй анхаарал хандуулах шаардлагатай боллоо.

Давос 2022 хэрхэн хувь нэмэр оруулах вэ?

Дэлхийн эдгээр сорилтод Давос хэрхэн эерэг хувь нэмэр оруулах вэ?

Хариулт нь гурван талтай.

Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагаа

Сорилтуудыг засгийн газар, бизнес эсвэл иргэний нийгэм дангаараа шийдвэрлэх боломжгүй. Дэлхийн эдийн засгийн форум нь 90 гаруй улсын засгийн газрын албан ёсны оролцоотой төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны олон улсын байгууллага юм.

Бидний олон талын хамтын санаачилга нь дэлхийн болон бүс нутгийн хамтын ажиллагааг бэхжүүлэх замаар ахиц дэвшил гаргах болно. Үүнд байгаль орчиныг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх; эдийн засаг, нийгмийн шинэ

бодлого боловсруулах; хариуцлагатай ESG салбарын өөрчлөлтийг хурдасгах, хиймэл оюун ухаан, блокчейн, квант тооцоолол зэрэг ахисан технологийг нийгмийн сайн сайхны төлөө ашиглах зэрэг хөгжил дэвшлийг гаргаж болно.

Уялдаа холбоо - системийн төвөгтэй байдал

Давос 2022 уулзалт нь тусгай үүрэг гүйцэтгэх өөр нэг шалтгаан бий. Сорилтууд нь улс төр, эдийн засаг, экологи, технологи, нийгмийн үр дагавар. Давос бол дэлхийн асуудлыг системийн хүрээнд ээдрээтэй байдлаар нь ойлгож, харах газар юм. Тиймээс энэ нь 400 гаруй хэсгээс бүрдэх маш баялаг хөтөлбөр билээ. Цаашлаад шинэ ойлголтыг олж авах, уялдаа холбоог сайжруулах, илүү оновчтой шийдвэр гаргахад хамтын болон хувь хүний дэмжлэг үзүүлэх талбар юм.

Оролцогч талуудын капитализм /stakeholder capitalism/

Эцэст нь, бизнес, эдийн засгийн үйл ажиллагааны тухайд Давосын уулзалт бол хувийн явцуу ашиг сонирхлын газар биш. Харин энэ нь 50 жилийн турш миний тэмцэж буй “оролцогч талуудын капитализм” гэх ойлголтыг хэрэгжүүлэх газар.

Энэ форум нь зөвхөн хувьцаа эзэмшигчид төдийгүй, оролцогч бизнесийг амжилттай эрхлэхэд чухал ач холбогдолтой. Миний “Оролцогч талуудын капитализм” номондоо бичсэнчлэн Давосын чуулган нь хөгжил цэцэглэлт, хүмүүс, дэлхий ертөнцийн сайн сайхан байдлын төлөө билээ.


Бид бүгд бие биентэйгээ дахин уулзалдахыг хүсч байна. Давосын хурлын уур амьсгал нь найрсаг, мөн хамгийн онцгой уулзалт байх болно. Иймд уг уулзалтын уур амьсгалыг сөргөөр харлуулах үйлдлүүдийг хүлээн зөвшөөрөхгүй бөгөөд Дэлхийн эдийн засгийн форум ямар нэг нийгэмлэгтэй холбоогүй байдаг.

Нэгтгэн хэлэхэд улам бутарч, олон талт уламжлалыг дагасан байгууллагуудын ихэнхийнх нь үйл ажиллагаа доголдож, үл итгэх хандлагатай болж байна. Ийм үед дэлхийн албан болон албан бус, итгэлцэлд суурилсан хамтын ажиллагааны платформ цаашид улам бүр хэрэгтэй байх болно.

МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХУДАЛДААНЫ ТЭНЦЭЛ, ГОЛ НЭР ТӨРЛИЙН ЭКСПОРТ, ИМПОРТЫН ТОО ХЭМЖЭЭ, ҮНЭ БОЛОН ТАТВАРЫН ОРЛОГО БҮРДЭЛТИЙН ТАЛААРХ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

(2022 оны нэгдүгээр улирлын гүйцэтгэл)

Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсээс гадаад худалдааны тэнцэл, экспорт, импорт, үнэ, татварын орлогын бүрдэлтийн 2022 оны нэгдүгээр улирлын гүйцэтгэлийн талаар бэлтгэсэн танилцуулгыг Та бүхний анхааралд толилуулж байна.



НЭГ. ГАДААД ХУДАЛДААНЫ ҮЗҮҮЛЭЛТ

Гадаад худалдааны нийт бараа эргэлт: 2022 оны нэгдүгээр улирлын гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлт 3,632.7 сая ам.долларт

хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 3.1 хувь буюу 108.6 сая ам.доллараар өсөж, гадаад худалдааны тэнцэл 251.4 сая ам.долларын ашигтай гарсан байна.

Хүснэгт 1. Гадаад худалдааны үзүүлэлт (сая ам.доллар)

Үзүүлэлт	Гуравдугаар сар (өссөн дүнгээр)				Өөрчлөлт (өмнөх оны мөн үеэс)	
	2019	2020	2021	2022	Дүн	Хувь
Нийт эргэлтийн бараа	3,057.4	2,197.4	3,524.1	3,632.7	108.6	3.1
- Экспорт	1,771.7	1,035.8	2,000.4	1,942.0	-58.4	-2.9
- Импорт	1,285.7	1,161.6	1,523.7	1,670.7	167.0	11.0
Тэнцэл	485.9	-125.8	467.7	251.4	-225.3	-47.3

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Гадаад худалдааны тэнцэл: 2022 оны нэгдүгээр улирлын гүйцэтгэлээр гадаад худалдааны тэнцэл 251.4 сая ам.долларын ашигтай гарсан байна. Өмнөх оны мөн үеэс 225.3 сая ам.доллар буюу 47.3 хувиар буурахад импорт 167.0 сая ам.доллараар өссөн, экспорт 58.4 сая ам.доллараар буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Экспорт: Экспортын худалдаа 2022 оны нэгдүгээр улирлын гүйцэтгэлээр 1,942.0 сая ам.доллар болж,

эдийн засаг хэвийн байсан 2019 оны мөн үетэй харьцуулахад 170.4 сая ам.доллар буюу 9.6 хувиар өссөн бол 2021 оны мөн үетэй харьцуулахад 58.4 сая ам.доллар буюу 2.9 хувиар буурсан байна.

Импорт: 2022 оны нэгдүгээр улирлын гүйцэтгэлээр импорт 1,690.7 сая ам.долларт хүрч, 2019 оны мөн үетэй харьцуулахад 404.9 сая ам.доллар буюу 13.0 хувиар, 2021 оны мөн үеэс 167.0 сая ам.доллар буюу 11.0 хувиар тус тус өссөн байна.

ХОЁР. ГОЛ НЭР ТӨРЛИЙН ЭКСПОРТЫН БҮТЭЭГДЭХҮҮН

Нийт экспортын 78.9 хувийг эрдсийн бүтээгдэхүүний экспорт, 21.1 хувийг эрдсээс бусад бүтээгдэхүүний экспорт эзэлж байна. Эрдсийн бүтээгдэхүүний экспорт 1,531.3 сая ам.доллар болж,

өмнөх оноос 244.9 сая ам.доллар буюу 13.8 хувиар буурсан бол эрдсийн бус бүтээгдэхүүний экспорт 410.7 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 186.5 сая ам.доллар буюу 83.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 2. Эрдсийн болон эрдсийн бус бүтээгдэхүүний экспорт (сая ам.доллар)

Үзүүлэлт	Гуравдугаар сар (өссөн дүнгээр)				Өөрчлөлт		Нийт экспортод эзлэх хувь
	2019	2020	2021	2022	Дүн	Хувь	
Эрдсийн бүтээгдэхүүний экспорт	1,478.9	886.0	1,776.2	1,531.3	-244.9	-13.8	78.9
Эрдсээс бусад бүтээг-дэхүүний экспорт	292.7	149.8	224.2	410.7	186.5	83.2	21.1
Нийт экспорт	1,771.7	1,035.8	2,000.4	1,942.0	-58.4	-2.9	100.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

ЭКСПОРТЫН ЗАРИМ ГОЛ НЭРИЙН БАРААНЫ ТОО ХЭМЖЭЭ, ҮНИЙН ДҮН

Нийт экспортын 36.6 хувийг зэсийн баяжмал, 34.8 хувийг нүүрс, 14.8 хувийг боловсруулаагүй алт, 3.0 хувийг төмрийн хүдэр, 2.1 хувийг цайрын баяжмал тус тус эзэлсэн байна.

Эрдсийн бүтээгдэхүүний экспорт өнгөрсөн оны мөн үеэс 244.9 сая ам.доллар буюу 13.8 хувиар буурахад голлон нөлөөлсөн бүтээгдэхүүнийг авч үзвэл:

1. Нүүрс: 2022 оны нэгдүгээр улирлын гүйцэтгэлээр 2.5 сая тн нүүрс экспортолж, 675.6 сая ам.долларын экспортын орлого олжээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нүүрсний экспортын биет хэмжээ 4.1 сая тн-оор, экспортын орлого 13.1 сая ам.доллар буюу 1.9 хувиар буурсан байна. Нэг тонн нүүрсний экспортын дундаж үнэ өмнөх оны мөн үеэс 167.4 ам.доллар буюу 1.6 дахин нэмэгдсэн байна.

2. Зэсийн баяжмал: Зэсийн баяжмалын экспортын орлого өнгөрсөн оны мөн үеэс 14.5 хувь буюу 89.8 сая ам.доллараар өсөж, 710.9 сая ам.долларт хүрсэн байна. Зэсийн баяжмалын экспортын биет тоо хэмжээ 334.8 мянган тн-д хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 5.8 хувь буюу 18.5 мянган тн-оор өссөн байна.

3. Төмрийн хүдэр: Төмрийн хүдрийн экспортын тоо хэмжээ 616.2 мянган тн болж, 57.5 сая ам.долларын экспортын орлого олсон байна. Төмрийн хүдрийн экспортын орлого өмнөх оны мөн үеэс 75.9 хувь буюу 181.1 сая ам.доллараар буурахад төмрийн хүдрийн биет хэмжээ 67.8 хувь буюу 1.3 сая тн-оор буурсан, мөн нэг тн төмрийн хүдрийн экспортын дундаж үнэ 23.7 хувиар буурсан нь тус тус нөлөө үзүүлжээ.

4. Цайрын баяжмал: Цайрын баяжмалын экспортын тоо хэмжээ 21.9 мянган тн болж, 41.2 сая ам.долларын экспортын орлого олсон байна. Цайрын баяжмалын экспортын орлого өмнөх оны мөн үеэс 11.3 хувь буюу 5.2 сая ам.доллараар буурахад цайрын баяжмалын биет хэмжээ 29.5 хувь буюу 9.1 мянган тн-оор буурсан нь нөлөөлжээ. Хэдийгээр нэг тн цайрын баяжмалын экспортын дундаж үнэ 25.7 хувиар нэмэгдсэн боловч экспортын тоо хэмжээний огцом бууралт экспортын орлого буурахад нөлөөлжээ.

5. Алт: Алтны экспортын тоо хэмжээ 4.8 тн-д хүрч, 288.0 сая ам.долларын экспортын орлого олсон байна. Алтны экспортын биет хэмжээ өмнөх оны мөн үеэс 9.9 дахин өссөн ба 2019 оны мөн үеэс 155.8 кг буюу 3.3 хувиар өссөн байна. Алтны экспортын орлого 288.0 сая ам.долларт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 10.2 дахин буюу 262.3 сая ам.доллараар

өсжээ. Харин нэг тн алтны экспортын дундаж үнэ 6.6 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

6. Катодын зэс буюу тунгаасан зэс ба хайлш:

Катодын зэсийн экспортын тоо хэмжээ 0.8 тн болж, 7.4 сая ам.долларын экспортын орлого олсон байна. Катодын зэсийн экспортын орлого 2020 оны мөн үеэс 57.0 хувь буюу 9.9 сая ам.доллараар, өмнөх оны мөн үеэс 72.8 хувь буюу 19.9 сая ам.доллараар тус тус буурсан байна. Нэг тн тунгаасан зэсийн экспортын дундаж үнэ 11.8 хувиар нэмэгдсэн боловч экспортын тоо хэмжээний огцом бууралт нь экспортын орлого буурахад нөлөөлжээ.

ГУРАВ. ГОЛ НЭР ТӨРЛИЙН ИМПОРТЫН БҮТЭЭГДЭХҮҮН

Нийт импортын 22.9 хувийг эрдсийн бүтээгдэхүүний импорт, 77.1 хувийг эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт тус тус эзэлж байна.

Эрдсийн бүтээгдэхүүний импорт 386.5 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 109.7 сая ам.доллар буюу 39.6 хувиар өссөн байна. Эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт 1,304.2 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеэс 57.3 сая ам.доллар буюу 4.6 хувиар өссөн байна.

Хүснэгт 3. Эрдсийн болон эрдсийн бус бүтээгдэхүүний импорт (сая ам.доллар)

Үзүүлэлт	Гуравдугаар сар (өссөн дүгээр)			Өөрчлөлт	Нийт импортод эзлэх хувь		
	2019	2020	2021		Дүн	Хувь	
Эрдсийн бүтээгдэхүүний импорт	315.4	284.0	276.8	386.5	109.7	39.6	22.9
Эрдсээс бусад бүтээгдэхүүний импорт	970.3	877.5	1,246.9	1,304.2	57.3	4.6	77.4
Нийт импорт	1,285.7	1,161.6	1,523.7	1,690.7	167.0	11.0	100.0

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Импортын барааны бүтцийн хувьд эрдэс бүтээгдэхүүн 22.9 хувь, машин механик тоног төхөөрөмж ба эд анги, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг 15.9 хувь, мал амьтан, ургамлын гаралтай бүтээгдэхүүн, хүнсний зүйл 15.4 хувь, авто болон агаарын тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд анги 13.1 хувь, үндсэн төмөрлөг болон түүгээр хийсэн бүтээгдэхүүн 9.4 хувь, химийн болон түүнтэй холбоотой үйлдвэрийн бүтээгдэхүүн 7.4 хувийг тус тус эзэлж байна.

ДӨРӨВ. УЛСЫН ТӨСВИЙН ГААЛИЙН ОРЛОГЫН БҮРДЭЛТ

Гаалийн байгууллага Сангийн сайдын 2022 оны гуравдугаар сарын 1-ний өдрийн “Төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай” 51 дүгээр тушаалаар батлагдсан төлөвлөгөөгөөр 2022 оны гуравдугаар сард улсын төсөвт 952.7 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэх төлөвлөгөөтэйгөөс 916.3 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж, 96.2 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 4. Татварын орлогын гүйцэтгэл

Үзүүлэлт	2021.03		2022.03		Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад		Төлөвлөгөөтэй харьцуулахад	
	Гүйц.	Төл.	Гүйц.	Төл.	Зөрүү	Хувь	Зөрүү	Хувь
Нийт орлого	790.3	952.7	916.2	916.2	125.9	115.9	-36.5	96.2
Гаалийн албан татвар	203.8	245.1	245.7	245.7	41.9	120.6	0.6	100.2
Нэмэгдсэн өртгийн албан татвар	417.0	505.4	502.7	502.7	85.7	120.6	-2.7	99.5
Архи, дарсны онцгой албан татвар	4.1	5.7	5.6	5.6	1.5	136.6	-0.1	98.2

Тамхины онцгой албан татвар	27.7	28.7	33.7	6.0	121.7	5.0	117.4
Шар айрагны онцгой албан татвар	0.9	0.5	0.9	0.0	100.0	0.4	180.0
Суудлын автомашины онцгой албан татвар	50.7	62.7	57.1	6.4	112.6	-5.6	91.1
Автобензин, дизель түлшний албан татвар	3.3	3.1	4.9	1.6	148.5	1.8	158.1
Экспортын татвар	0.024	0.002	0.01	-0.01	0.0	0.01	0.0
Татварын дүн	775.1	934.8	907.8	132.7	117.1	-27.0	97.1
Өөрийн орлого	1.0	4.5	1.9	0.9	190.0	-2.6	42.2
Хураамж	14.2	13.4	6.5	-7.7	45.8	-6.9	48.5

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Орлогын гүйцэтгэлийг өнгөрсөн онтой харьцуулбал нийт орлого 125.9 тэрбум төгрөгөөр өсчээ. Үүнд:

- Гаалийн албан татвар 41.9 тэрбум төгрөг;
- Нэмэгдсэн өртгийн албан татвар 85.7 тэрбум төгрөг;
- Архи, дарсны онцгой албан татвар 1.5 тэрбум төгрөг;
- Тамхины онцгой албан татвар 6.0 тэрбум төгрөг;
- Суудлын автомашины онцгой албан татвар 6.4 тэрбум төгрөг;
- Автобензин, дизель түлшний албан татвар 1.6 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Харин Автобензин, дизель түлшний онцгой албан татвар 10.4 тэрбум төгрөг, хураамжийн орлого 7.7 тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.

Хураамжийн орлого: Гаалийн байгууллага улсын төсөвт хураамжийн орлогоор 13.4 тэрбум

төгрөг төвлөрүүлэх төлөвлөгөөтэйгөөс 6.5 тэрбум төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөний гүйцэтгэл 48.5 хувьтай байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад хураамжийн орлого 7.7 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

Экспортод гаргасан эрдэс бүтээгдэхүүний гаалийн бүрдүүлэлтийн хураамж нь нийт хураамжийн орлогын 92.0 хувийг эзэлж байна

ТАВ. ТАТВАРЫН ЧӨЛӨӨЛӨЛТ

2022 оны нэгдүгээр улирлын гүйцэтгэлээр нийт татвараас чөлөөлөгдсөн импорт үнийн дүнгээр 158.8 тэрбум төгрөг буюу нийт импортын 3.3 хувийг эзэлж байна. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад татвартай импорт 766.9 тэрбум төгрөг буюу 1.2 дахин өссөн бол, татвараас чөлөөлөгдсөн импорт 320.6 тэрбум төгрөг буюу 33.1 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Татвараас чөлөөлөгдсөн импортын нийт импортод эзлэх хувь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 7.8 нэгж хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 5. Импортын бүтэц (тэрбум төгрөг)

Үзүүлэлт	2021.01	2022.01	Өөрчлөлт (+,-)	Хувиар, %
Татвартай импорт	3,828.5	4,595.4	766.9	120.0
Эзлэх хувь	88.9%	96.7%	7.8%	
Татвараас чөлөөлөгдсөн импорт	479.4	158.8	-320.6	33.1
Эзлэх хувь	11.1%	3.3%	-7.8	
Нийт импорт	4,307.9	4,754.2	446.2	110.4

Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

2022 оны нэгдүгээр улирлын гүйцэтгэлээр 158.8 тэрбум төгрөгийн импортын бараанд ногдох 27.3 тэрбум төгрөгийн татвар хуулийн дагуу чөлөөлөгдсөн байна. Чөлөөлөгдсөн татварын дүнг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 51.8 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.

ЗУРГАА. УЛСЫН ТӨСВИЙН ГААЛИЙН ОРЛОГЫН БҮРДЭЛТЭД НӨЛӨӨЛСӨН ХҮЧИН ЗҮЙЛ

Импорт: Эдийн засгийн нөхцөл байдал эргэн сэргэж гадаад худалдааны бараа эргэлт нь өмнөх оны мөн үеэс 3.1 хувиар илүү байна.

— Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 338 дугаар тогтоолын дагуу гаалийн байгууллага нь гадаад худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой ажлуудыг эхлүүлсэн байна. Тухайлбал, Замын-Үүд дэх гаалийн газар чингэлэг терминалын үйл ажиллагааг эхлүүлсэнтэй холбогдуулан уртасгасан цагаар ажиллаж, ААН, иргэдийн ачааг олгож байна.

— Коронавируст цар тахлын улмаас БНХАУ-ын Эрээн хотын боомтод хийсэн бараа эргэлтийн хязгаарлалтаас хамаарч агаарын тээвэрлэлт 4-5 дахин өссөн үзүүлэлтэй байна. Чингис хаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газар уртасгасан цагаар ажиллаж байна.

Татварын чөлөөлөлт: Татвараас чөлөөлөгдсөн импортын нийт импортод эзлэх хувь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 7.8 нэгж хувиар буурсан үзүүлэлттэй байгаа нь 2021 онд хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан (*Хүнсний гол нэр төрлийн бүтээгдэхүүн, малын тэжээлийг Гаалийн болон НӨАТ-аас чөлөөлөх, Коронавируст халдварын цар тахлын оношилгоо, эмчилгээнд хэрэглэх зорилгоор импортоор оруулж ирсэн оношлуур, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодис амны хаалтыг гаалийн болон НӨАТ-аас чөлөөлөх тухай*) хуулийн дагуу нийт 45.3 тэрбум төгрөгийг татвараас чөлөөлснөөс шалтгаалсан байна.



САНХҮҮГИЙН БОЛОВСРОЛЫГ СУУРЬ БОЛОВСРОЛ ГЭЖ ҮЗЭЖ БАЙНА

Улс орны санхүүгийн системийн тогтвортой байдлыг урт хугацаанд хангах, санхүүгийн салбарын хөгжлийн нэг шалгуур нь тухайн улсын иргэдийн санхүүгийн мэдлэг, түүнийгээ амьдралд хэрэгжүүлэх чадвараар тодорхойлогддог.

Санхүү эдийн засгийн тогтворгүй байдалтай холбогдуулан бодлого боловсруулагчдын түвшинд санхүүгийн боловсролд анхаарах талаар илүү эрчимтэй ажиллаж эхэлсэн бөгөөд энэхүү хандлага нь олон улсын бодлогын хэмжээний баримт бичигт тусгагдах болсон. Нөгөө талаас санхүүгийн харилцаанд оролцогч үндсэн субъектууд болох хувь хүн, өрх гэр, аж ахуй нэгж, бизнес эрхлэгч хэн бүхэнд санхүүгийн сайн мэдлэг, боловсролтой байх шаардлагыг ОУ-ын байгууллагууд 20-иод жилийн өмнөөс тодорхойлж ирсэн. Тухайлбал, 1990-ээд оны сүүлийн үеийн санхүүгийн хямралуудын дараа 2000 оноос эхлэн Япон, Голланд, Шинэ Зеланд, Сингапур, Их Британи болон АНУ зэрэг өндөр

хөгжилтэй орнууд санхүүгийн боловсролыг дээшлүүлэхээр судалгаа шинжилгээ хийж, төрөл бүрийн шат дараалалтай төсөл, хөтөлбөрүүдийг амжилттай хэрэгжүүлж, цаашлаад үндэсний стратегийн хэмжээнд авч үзэх болсон. 2011 онд хөгжсөн болон хөгжиж буй 26 орон санхүүгийн мэдлэг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байдаг бол 2021 онд 129 орон болж тэлсээр байна. Санхүүгийн хүртээмжийг сайжруулах, санхүүгийн хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор иргэд, бичил, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх нь өнөөгийн манай нийгэм, эдийн засгийн хөгжлөөс урган гарч байгаа шаардлага юм. Иргэд урт хугацааны санхүүгийн шийдвэр гаргахдаа хүндрэлтэй тулгарах асуудал байсаар байгаа нь тухайн өрх гэрийн санхүүгийн байдалд төдийгүй улс орны санхүү эдийн засгийн тогтвортой байдалд нөлөөлдөг.

Манай улсын хувьд ч иргэдийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх тал

дээр анхаарч мэргэжлийн байгууллагуудтай хамтран Дэлхийн банкны тусламжтайгаар удаа дараагийн уулзалт, хэлэлцүүлгийн үр дүнд “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр”-ийг боловсруулж 2015 онд батлуулсан юм. Тус хөтөлбөр нь 2016-2021 онд хэрэгжүүлэхээр боловсруулж, 2 үе шаттайгаар хэрэгжүүлж, хамрагдах хүрээллийг сургуулийн нас, залуу үе, хөдөө, орон нутгийн иргэд, цахим хуудас болон олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулж нийт иргэдэд хүргэх замаар хэрэгжүүлж дуусаад байна. Энэ хугацаанд ерөнхий боловсролын сургууль болон их дээд сургуулийн хичээлийн хөтөлбөрт санхүүгийн боловсрол олгох хичээлийг оруулахад анхаарч ажиллаж ирлээ. Үр дүнд нь магадлан итгэмжлэгдсэн 13 их дээд сургуульд 3 кредитийн “Хувь хүний санхүү” хичээлийг үндсэн сургалтын хөтөлбөрт нь оруулж, сургалтын агуулга, сурах бичгүүдийг боловсруулсан бол ЕБС-ийн сургуулиудад Бизнес судлал хичээлийг боловсруулан



мөн хөтөлбөрт нь тусгуулаад байна. Энэ хүрээнд одоогийн байдлаар ЕБС-ийн ахлах ангид "Бизнес судлал" хичээлийг сонгон судалж үзэх боломжтой байдлаар 2017 оноос эхлүүлж, холбогдох гарын авлагуудыг боловсруулсан. Зөвхөн хичээлийн агуулгыг боловсруулахын хамт тус хичээлийг заах түүх, нийгмийн ухааны 1870 багшийг чадавхжуулахад Боловсролын хүрээлэн, Багшийн мэргэжил дээшлүүлэх институттай Монголбанкны Олон нийтийн санхүүгийн боловсролын төв хамтран ажилласан билээ.

Дэлхийн бусад орнууд ч санхүү, эдийн засгийн мэдлэг олгох хичээлийг боловсролын бүх шатандаа нэвтрүүлэн нэн ялангуяа ЕБС-ийн хүүхдүүдийг багаас нь хувийн санхүүгээ зохистой удирдах, санхүүгийн бүтээгдэхүүн үйлчилгээний талаар мэдлэгтэй болгох, цаашлаад өөрсдийн санхүүгийн шийдвэр гаргалтандаа ухаалгаар хандахад нь анхаарч хичээлийн хөтөлбөрт нь заавал судлах байдлаар агуулгыг нь оруулж өгсөн байдаг. Тухайлбал, Ази тивийн зарим орнуудын туршлагыг авч үзэхэд БНХАУ-ын Шанхай

хотын бага, дунд сургуулиудад "Санхүү ба мөнгөний менежмент" хичээлээр, Япон улсад үндэсний сургалтын хөтөлбөрт зааснаар бага, дунд сургуульд санхүүгийн боловсролын агуулгыг нийгэм судлал, өрхийн эдийн засаг (home economic), ёс суртахууны боловсрол зэрэг хичээлүүдийн агуулгаар дамжуулан заадаг бол Малайз, Индонез, Тайван, Өмнөд солонгос, зэрэг улсуудад бага, бүрэн дунд сургуулийн сонгогдсон үндсэн хичээлүүд болох математик, нийгмийн шинжлэх ухаан, иргэний

боловсрол зэрэг хичээлүүдэд санхүү, эдийн засгийн боловсролын агуулгыг нэг хэсэг болгон багтаасан байдаг байна.

Эдгээр улс орнууд болон дэлхийн томоохон улсуудын туршлагад үндэслэн Монгол Улсын хувьд хүүхэд багачуудыг сургуулийн бага ангиас нь санхүү, эдийн засгийн суурь мэдлэг олгох чиглэлд ач холбогдол өгч иргэний боловсрол, нийгмийн ухаан, математик зэрэг хичээлийн агуулагад нэгтгэн оруулах эсхүл хувь хүний санхүү, эдийн засгийн мэдлэгийг олгох хичээлийг сургалтын хөтөлбөртэй нь уялдуулах байдлаар нэвтрүүлэх нь одоо хэрэгжиж буй олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөрийн хэрэгжилтийн үр нөлөө, хүртээмжийг нэмэгдүүлэх юм.





Гар дамжуулахгүй

* Пин кодгүй

EMV чиптэй